

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ



МОНГОЛЫН ГАРААНЫ БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХҮРТЭЭМЖ СУДАЛГАА

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
БҮЛЭГ 1. УДИРТГАЛ	7
1.1 Судалгааны үндэслэл	7
1.2 Судалгааны зорилго	8
БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	9
2.1 Судалгааны хамрах хүрээ	9
2.2 Мэдээлэл цуглуулсан аргачлал	9
2.3 Судалгааны зохион байгуулалт	10
2.4 Судалгааны хязгаарлагдмал байдал	10
БҮЛЭГ 3. ИННОВАЦ БОЛОН ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА	11
3.1 БНСУ-ын гарааны бизнесийн хөгжил ба өнөөгийн нөхцөл байдал	11
3.2 Сингапур улсын гарааны бизнесийн хөгжил ба өнөөгийн нөхцөл байдал	15
3.3 Израйл улсын гарааны бизнесийн хөгжил ба өнөөгийн нөхцөл байдал	23
БҮЛЭГ 4. МОНГОЛ УЛСЫН ГАРААНЫ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	28
4.1 Монголын мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн хөгжил олон улсад	28
4.2 Гарааны бизнесийн экосистемийн төлөв байдал	29
4.3 Бодлого, зохицуулалт, хууль эрх зүйн орчин	33
4.4 Гарааны бизнесийн санхүүжилт, хөрөнгө оруулалт	41
БҮЛЭГ 5. ГАРААНЫ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН	52
БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	61
6.1 Дүгнэлт	61
6.2 Зөвлөмж	62
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	65
ХАВСРАЛТ	66

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
ЖАЙКА	Японы Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
МТҮП	Мэдээлэл технологийн үндэсний парк
ДСЭТ	Дэлхийн гарааны компаниудын экосистемийн тайлан
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОУБ	Олон Улсын Байгууллага
ДӨӨБ	Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Дэлхийн инновацын индексийн үзүүлэлт	28
Зураг 2. Гарааны бизнес эрхлэгчдийн өсөлт	30
Зураг 3. Гарааны компаниудын бүтэц (дэд салбараар)	31
Зураг 4. Гарааны бизнесийн хөгжлийн үе шат, хөрөнгө оруулалтын хамаарал.....	42
Зураг 5. Анхны санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл	47
Зураг 6. Явцын санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл	47
Зураг 7. Явцын санхүүжилтийн дундаж хэмжээ (дэд салбараар, тэрбум төгрөг)	48
Зураг 8. Санхүүжилтийн эх үүсвэр.....	52
Зураг 9. Санхүүжилтийн хэлбэр	53
Зураг 10. Санхүүжилт олгож буй байгууллагын эзлэх хувь болон хөрөнгө оруулалтын хэлбэр..	54
Зураг 11. Санхүүжилт олгосон хэлбэр.....	54
Зураг 12. Гарааны компаниудын авсан санхүүжилтийн төрөл.....	55
Зураг 13. Гарааны компаниудын авсан санхүүжилтийн эх үүсвэр	56
Зураг 14. Гарааны компаниудын хөрөнгө оруулалт татсан үе шатууд.....	57
Зураг 15. Гарааны компаниудын үе шат болон татсан мөнгөн дүн (төгрөгөөр)	57
Зураг 16. Гарааны бизнесийн чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээ	59

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Гарааны бизнесийн экосистемийн харьцуулалт	31
Хүснэгт 2. Гарааны бизнесийн санхүүжүүлэх түгээмэл арга	42
Хүснэгт 3. Гарааны бизнесийн экосистемийг бий болгохтой холбоотой хөгжлийн түншүүдийн дэмжлэгийн агуулга.....	49
Хүснэгт 4. Жижиг, дунд үйлдвэрийн сангаас олгосон төслийн мөнгөн дүн эдийн засгийн салбараар (зуун сая төгрөг)	50
Хүснэгт 5. Гарааны компанийн санхүүжилт авсан үнийн дүн.....	55
Хүснэгт 6. Гарааны компаниудын хэрэгцээт санхүүжилт (үе шатаар)	58
Хүснэгт 7. Гарааны бизнесийн чиглэлээр 2025 онд болох арга хэмжээ	60

БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

1.1 Судалгааны үндэслэл

Монгол Улс нь сүүлийн жилүүдэд уламжлалт уул уурхай, хөдөө аж ахуйн салбаруудаас гадна эдийн засгаа солонгоруулах, дижитал шилжилтийг эрчимжүүлэх зорилгоор инновац, технологийн салбарт ихээхэн анхаарал хандуулж байна. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт "технологид суурилсан инновацыг бий болгохыг зорино" хэмээн тусгаж, 2022 онд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам (ЦХИХХЯ)-ыг байгуулж, нээлттэй өгөгдлийг ашиглах, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, мэдээллийн болон дэвшилтэт технологийн үйлдвэрлэлийг бэхжүүлэх, гарааны бизнесийг дэмжих нь Монгол Улсын цаашдын аж үйлдвэрийн хөгжлийн хөдлөх хүч болно хэмээн үзэж байна.

Энэхүү хүрээнд гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлснээр улс орны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж, шинэ ажлын байр бий болгох, эдийн засгийн өсөлтийг тэтгэх, олон улсад өрсөлдөхүйц бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох боломжтой юм. Гэсэн хэдий ч, дэлхийн бусад хөгжиж буй экосистемүүдийн нэгэн адил Монголын гарааны бизнесийн орчин нь санхүүжилт, дэд бүтэц, хууль эрх зүйн зохицуулалт зэрэг олон талын сорилттой тулгарч байна.

Одоогийн байдлаар Монгол Улсын гарааны бизнесийн экосистемийн нэгдсэн мэдээлэл, түүнийг тайлагнах тогтолцоо бүрэн тогтоогүй байгаа нь салбарын хөгжилд томоохон саад болж байна. Япон Улсын хамтын ажиллагааны байгууллага болох ЖАЙКА-ын санхүүжилтээр 2022, 2023 онд хийгдсэн судалгаа, "Старт" ХХК-иас гаргадаг "Монголын гарааны бизнесийн зураглал" зэргээс өөр томоохон, нэгдсэн мэдээлэл, харьцуулсан дүн шинжилгээ хомс байсаар байна. Энэхүү мэдээллийн дутмаг байдал нь бодлого тодорхойлогчид, хөрөнгө оруулагчид, гарааны бизнес эрхлэгчдэд зөв шийдвэр гаргахад хүндрэл учруулж, экосистемийн бодит байдлыг үнэлэх боломжийг хязгаарлаж байна. Олон улсад өрсөлдөхүйц гарааны бизнесийг хөгжүүлэхийн тулд юуны түрүүнд дотооддоо тэдгээрийг хэмжих, үнэлэх, хөгжлийн түвшинг тодорхойлох тогтолцоо чухал юм.

1.2 Судалгааны зорилго

Монгол Улсад сүүлийн жилүүдэд технологид суурилсан, шинэлэг санааг хэрэгжүүлэгч гарааны бизнесүүд эрчимтэй бий болж, эдийн засгийн өсөлтийн шинэ хөшүүрэг болон төлөвшиж байна. Гэвч эдгээр гарааны компаниудын өсөлтийг дэмжих санхүүжилтийн хүртээмж, хөрөнгө оруулалтын орчин нь олон асуудалтай хэвээр байна. Энэ судалгааны зорилго нь 2024-2025 оны байдлаарх Монголын гарааны бизнесийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн бүтцэд дүн шинжилгээ хийж, боломжуудыг тодорхойлж, бодлогын зөвлөмж боловсруулахад оршино.

БҮЛЭГ 2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1 Судалгааны хамрах хүрээ

Гарааны бизнесийн экосистемийн санхүүжилтийн хүртээмжийг тодорхойлох энэхүү судалгаанд хоёрдогч мэдээллийн эх үүсвэрийг ашиглан санхүүжилтийн нөхцөл байдлыг үнэлэхээс гадна, нийт 80 байгууллагын төлөөллийг хамруулсан (эдгээрээс 35 нь гарааны бизнесийн экосистемийн оролцогч байгууллага, 45 нь гарааны компани бизнес эрхлэгч) анкетын аргаар тоон мэдээлэл цуглуулан шинжилгээ хийлээ.

Уг судалгаанаас цугларсан өгөгдөл, мэдээллийг график, хүснэгт, харьцуулалт зэрэг олон хэлбэрээр боловсруулж, задлан шинжилж, бусад байгууллагаас хийсэн судалгааны статистик үзүүлэлттэй харьцуулан авч үзлээ. Судалгаанд оролцсон бизнесийн экосистемийн оролцогч 35 байгууллагыг дараах байдлаар ангилав:

- Бизнесийн байгууллагууд, хөрөнгө оруулалтын сангууд – 13;
- Их, дээд сургууль, Шинжлэх ухаан болон эрдэм шинжилгээний байгууллага, гарааны бизнесийн хөгжил, инновацыг дэмжих төвүүд – 10;
- Засгийн газрын яам, агентлагууд – 6;
- Төрийн бус байгууллага – 4;
- Олон улсын байгууллага – 2.

2.2 Мэдээлэл цуглуулсан аргачлал

Судалгааны мэдээлэл цуглуулах гол хэрэгсэл нь урьдчилан бүтэцлэгдсэн асуулгын хуудас болон ярилцлагын арга бөгөөд асуулгын чиглэлийг захиалагчаар хянуулсан. Экосистемийн оролцогч байгууллагуудаас асуулгын хуудас болон нүүр тулсан ярилцлагын аргаар санхүүжилт олгосон хэмжээ, төрөл, хэлбэр, оролцсон гарааны бизнесүүдийн тоо зэрэг мэдээллийг цуглуулсан.

Харин гарааны бизнес эрхлэгчээс санхүүжилтийн хүртээмж, хөрөнгө оруулалтын хэрэгцээ, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох зорилгоор асуулгын аргаар мэдээлэл цуглуулсан. Судалгааны асуулгуудыг хавсралтаас харна уу. Үүнд:

1. Гарааны бизнесийн экосистемийн оролцогч байгууллагаас авах судалгааны асуулга (9 асуулттай);
2. Гарааны компани бизнес эрхлэгчдээс авах судалгааны асуулга (7 асуулттай).

2.3 Судалгааны зохион байгуулалт

Судалгааг нүүр тулсан ярилцлагын хэлбэрээр цуглуулсан бөгөөд асуулгын үнэн зөв, бөглөсөн байдлыг мэдээлэл цуглуулах багийн ахлагч газар дээр нь тухай бүрд нь шалгаж, алдааг залруулах, дутууг нөхөх зэргээр асуулгын хуудасны бүрэн, чанартай байдлыг баталгаажуулсан.

Судалгааны тоон мэдээллийг үнэн бодитой, чанартай байлгахын тулд мэдээлэл цуглуулалтын өмнө судлаач, тоологчдыг сургалтад хамруулснаар чиг үүргийнхээ хүрээнд судалгааны ажлын удирдамжийг мөрдлөг болгосон ба тэдгээрийн мэдээлэл цуглуулалтад багийн ахлагч хяналт тавьж, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хариуцан ажилласан.

Судлаач болон мэдээлэл цуглуулагчдын сургалт: Мэдээллийг цуглуулахад нийт 4 судлаач оролцсон бөгөөд эдгээр мэдээлэл цуглуулагч нарт зориулан уг судалгааны зорилго, зорилт, хүлээгдэж буй үр дүн, асуулгын хуудсыг бөглөх ерөнхий арга зүй, мэдээлэл цуглуулахад анхаарах асуудал, зөвлөмж, хуваарилалт болон бусад холбогдох мэдээллийн талаар сургалт орж, удирдамжийг өгсөн.

Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт: 35 гарааны бизнесийн экосистемийн оролцогч байгууллага болон 45 гарааны компани бизнес эрхлэгч байгууллагаар асуулгын хуудсыг бөглүүлэн, тоон судалгааны мэдээллийг цуглуулсан. Судалгаанд хамрагдсан байгууллагуудын хувьд мэдээллээ нээлттэй ил тод өгсөн бөгөөд зарим бизнесийн нууцтай холбоотой мэдээллийг салбар, бүлгээр нь нэгтгэж гаргасан болно. Тоон судалгааны мэдээллийг SPSS программ ашиглан, статистикийн шинжилгээний аргаар боловсруулж, судалгааны үр дүнгүүдийг нэгтгэн энэхүү тайланг боловсруулав.

2.4 Судалгааны хязгаарлагдмал байдал

Баримт бичгийн судалгаа, холбогдох статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх явцад гарааны бизнестэй холбоотой тоо баримт, статистик мэдээллийн олдоц муу, гарааны бизнес болон түүний санхүүжилтийн талаарх ойлголт, мэдлэг харилцан адилгүй байдал нь судалгааны үр дүнг тооцоход хязгаарлагдмал байдлыг үүсгэсэн.

БҮЛЭГ 3. ИННОВАЦ БОЛОН ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

3.1 БНСУ-ын гарааны бизнесийн хөгжил ба өнөөгийн нөхцөл байдал

Бүгд Найрамдах Солонгос Улс нь 1990 оноос эхлэн эскпортыг дэмжиж үйлдвэрлэл болон технологид суурилсан үйлчилгээ, мэдлэг, инновац, дижитал шилжилтэнд тулгуурласан эдийн засаг руу хурдацтай шилжсэн. Энэ үеэр гарааны бизнес болон жижиг, дунд үйлдвэрлэлүүд эдийн засаг тэлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан.

ЖДҮ нь БНСУ-ын эдийн засгийн гол тулгууруудын нэг бөгөөд олон үүргийг гүйцэтгэдэг. Албан ёсны тоо мэдээллээр улсын хэмжээнд бүртгэлтэй нийт аж ахуйн нэгжийн 99 хувийг ЖДҮ-үүд бүрдүүлж байгаа нь эдийн засгийн өрсөлдөх чадвартай болохыг харуулж байна. Мөн нийт ажиллах хүчний 83 хувь нь эдгээр салбарт ажилладаг бөгөөд энэ нь хөдөлмөрийн зах зээлийн тогтвортой байдал, нийгмийн дунд давхаргын тэлэлтэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Мөн экспортын нийт хэмжээний 34 хувийг ЖДҮ-үүд гаргаж буй нь тэд зөвхөн дотоодын биш, гадаад зах зээлд ч амжилттай өрсөлдөж байна¹.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас 2020 онд нийтэлсэн “Дэлхийн санхүүгийн хямралаас хойш үеийн ЖДҮ-ийн санхүүгийн бодлого, хөгжил, хандлагууд” тайланд дурдсанаар, БНСУ-ын Засгийн газар сүүлийн жилүүдэд технологи, инновацийн чадавхыг идэвхтэй ашиглан шинэ төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн нь ЖДҮ эрхлэгчдийн санхүүжилтэд хамрагдах боломж, механизмыг бодлогын түвшинд шинэчлэн сайжруулах нөхцөл бүрдүүлсэн гэж онцолжээ.

БНСУ-ын Засгийн газраас 2017 онд хуучнаар Жижиг Дунд Бизнесийн Удирдах Газрыг, Жижиг Дунд Үйлдвэр, Гарааны Бизнесийн Яам (Ministry of SMEs and Startups Agency-MSS) болгон шинэчлэн байгуулсан байна. Энэхүү байгууллага нь дараах гурван чиглэлээр Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлдэг, гарааны бизнесийг дэмжих гол бүтэц юм.. Үүнд:

1. ААН-ийн өсөлт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны цар хүрээг тэлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх;
2. Шинээр бизнес эрхлэх гэж буй иргэдэд санаагаа хөгжүүлэхэд туслах, хөрөнгө оруулах, хөнгөлөлттэй зээл олгох, бусад төрлийн санхүүжилт олгох;
3. Гарааны бизнесийг дэмжих, өрсөлдөх чадварыг нь бэхжүүлэх зорилгоор бизнесээ амжилттай эхлүүлж, тогтвортой үйл ажиллагаа эрхлэх

¹ Ministry of SMEs and Startups

боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогыг боловсруулан хэрэгжүүлдэг.


Мөн энэ яам нь бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг боловсруулж, дараах арга хэмжээг хэрэгжүүлдэг. Үүнд санхүүжилтийн шалгуур тогтоох, бодлогын зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрсөн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, бизнесийн эргэлтийг дэмжих, шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг орно. Эдгээр бодлого, арга хэмжээ нь ЖДҮ эрхлэгчдийн тогтвортой өсөлт, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн бүтэц дэх тэдний оролцоог өргөжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

Ийм суурь нөхцөл бүрдсэнээр БНСУ зах зээлийн зарчимд нийцсэн, олон шатлалт хяналттай Fund of Funds (FoF) тогтолцоог стратегийн хувьд оновчтой шийдэл хэмээн тодорхойлж, хэрэгжүүлсэн байна. Тус бүтэц нь төрийн шууд оролцоог хязгаарлан, мэргэжлийн менежменттэй бие даасан сангуудаар дамжуулан хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлдэг тул бодлогын уян хатан байдал, зах зээлийн хариу үйлдлийн үр нөлөөг сайжруулж, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлсэн байна.

FoF тогтолцоог нэвтрүүлэхэд шаардагдах институтийн зохион байгуулалт, эдийн засгийн суурь нөхцөл, бодлогын уялдаа, хууль эрх зүйн орчин зэрэг нь хэрэгжүүлэлтийн өмнөх үеэс хангагдсан байсан нь уг механизмыг тогтвортой хөгжих үндэс болсон гэж судлаачид үздэг. Үүний үр дүнд БНСУ-д FoF тогтолцоо нь зөвхөн хөрөнгө оруулалтын механизмын үр ашгийг нэмэгдүүлэхээс гадна, санхүүгийн зах зээлийн төлөвшил, хөрөнгө оруулалтын экосистемийн цогц бүтэц бүрэлдэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж дүгнэж болно.

Хөрөнгө оруулалтын бүтэц, загвар: БНСУ-д Fund of Funds (FoF) тогтолцоог албан ёсоор 2005 онд Korea Venture Investment Corporation (KVIC)-ийг байгуулснаар нэвтрүүлжээ. KVIC нь төрөөс олгосон хөрөнгийг FoF хэлбэрээр удирдаж, венчур хөрөнгө оруулалтын сангуудад Limited Partner (LP) хэлбэрээр хөрөнгө оруулалт хийдэг дамжуулагч институтийн үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү бүтэц нь гарааны бизнесүүд рүү шууд хөрөнгө оруулахын оронд хөрөнгийн урсгалыг зах зээлийн зарчимд нийцүүлэн зохион байгуулах, хөрөнгө оруулалтын эрсдэл, мэдээллийн зөрүү зэрэг асуудлыг бууруулахад онцгой ач холбогдолтой. Түүнчлэн уг тогтолцоо нь Солонгосын гарааны бизнес, венчур экосистемийг дэмжих, хөрөнгө оруулалтын зах зээлийг хөгжүүлэх суурь болж, цаашид удирдлага, хяналт- шинжилгээний механизм, технологийн дэвшил, төр-хувийн хэвшлийн харилцаанд онцгой анхаарал хандуулан тасралтгүй хөгжиж ирсэн байна.

Зураг 2. KFoF загварын оролцогчид, тэдгээрийн ажиллах зарчим²



БНСУ-д Fund of Funds (FoF) тогтолцоо нь зах зээлийн зарчимд тулгуурласан, хөрөнгө оруулалтын давхар бүтэц бүхий санхүүгийн зохион байгуулалттайгаар хэрэгжиж байна. Энэхүү систем нь шууд хөрөнгө оруулалт хийхээс илүүтэйгээр зуучлагч институцуудын гинжин хэлхээ үүсгэх замаар, эрсдэл бууруулах, хөрөнгө хуваарилалтын оновчлолыг нэмэгдүүлэх, удирдлагын хяналтыг сайжруулах онцлогтой.

² (KVIC, 2025)

Тогтолцооны хамгийн дээд түвшинд Засгийн газар стратегийн бодлогын чиглэлүүдээ тодорхойлж, салбаруудын өсөлтийг дэмжих зорилгоор хөрөнгө хуваарилдаг. Энэ хөрөнгө нь Korean Fund of Funds (KFoF) институцээр дамжин, хөрөнгө оруулалтын сангууд руу шилждэг. KFoF нь өөрөө хөрөнгө оруулалт хийдэггүй, харин LP (Limited Partner) буюу хязгаарлагдмал түншийн байр сууринаас ажиллаж, сангуудыг шалгууртайгаар сонгож, хамтын хөрөнгө оруулалтаар дамжуулан зах зээлд чиглэсэн хандлага баримталдаг.

Дараагийн шатанд, хамтарсан хөрөнгө оруулалтын сангууд (VC, PE, Growth funds гэх мэт) байрладаг. Эдгээр нь GP (General Partner) хэлбэрээр хөрөнгийг идэвхтэй удирдах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах бүрэн эрхтэй бөгөөд, сангууд нь ихэвчлэн салбарын онцлог, хөгжлийн шат, хөрөнгө оруулалтын хэмжээ, эргэн төлөлтийн боломж зэргийг харгалзан гарааны болон өсөлтийн шатандаа явж буй ЖДҮ, инновацын бизнесүүдэд хөрөнгө оруулалт хийдэг.

Ийнхүү гарааны бизнесүүд, ЖДҮ-үүд нь энэхүү давхар бүтэц бүхий механизмаар дамжин хөрөнгийн хүртээмжтэй болж, технологи инноваци дээр суурилсан шийдлүүдээ арилжааны түвшинд гаргах, зах зээлд оролцох, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх боломж бүрддэг. Тухайлбал, урт хугацаанд өсөлт харагдаж буй компаниуд энэхүү сангуудын дэмжлэгтэйгээр IPO хийх, гадаадын хөрөнгө оруулагч татах, эсвэл өөр венчур сангуудтай дахин санхүүжилт босгох боломжтой болдог.

2024 оны эцсийн байдлаар БНСУ-ын "Fund of Funds" (KFoF) нь нийт 9.86 их наяд воны хөрөнгө босгосон байна. Гадаад хөрөнгө оруулагчдын оруулсан нийт хөрөнгө 28.74 их наяд вонд хүрч, өмнөх онтой харьцуудахад өсөлттэй гарчээ. Үүний үр дүнд, KFoF-ийн дэмжлэгтэйгээр нийт 1327 хөрөнгө оруулалтын сан байгуулагдаж, тэдгээрийн хөрөнгө оруулхаар төлөвлөсөн нийт хөрөнгө 43.94 их наяд вонд хүрсэн байна. Одоогоор эдгээрээс 1026 сан идэвхтэй үйл ажиллагаа явуулж, нийт 35.19 их наяд вон хөрөнгийг удирдаж байна.

Үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш KFoF нь эдгээр суурь сангийнхаа хүрээнд нийт 10729 компанид хөрөнгө оруулалт хийсэн байна (Korean Venture Investment Corporation, 2024).

Хөрөнгө оруулагчдыг ангидан харвал Бодлогын чиг үүрэг бүхий байгууллагууд буюу төрийн санхүүжилтийн байгууллагууд, KFoF болон бусад бүтэц хамгийн том хөрөнгө оруулагчид байсан бөгөөд нийт 20.35 их наяд вон (46.3 хувь)-ийг бүрдүүлжээ. Үүнээс гадна санхүүгийн байгууллагууд 6.57 их наяд вон (15.0 хувь) болон хувийн аж ахуйн нэгжүүд 5.47 их наяд вон (11.0 хувь)-ийг бүрдүүлжээ.

3.2 Сингапур улсын гарааны бизнесийн хөгжил ба өнөөгийн нөхцөл байдал

Сингапур Улс бол хөгжлийн төлөвлөгөөгөө оновчтой боловсруулж, үе шаттай хэрэгжүүлсний үр дүнд дэлхийн хамгийн өрсөлдөх чадвартай, өндөр орлоготой эдийн засагтай улс орны нэг болж чадсан цөөн жишээнүүдийн нэг юм. Анх 1965 онд тусгаар тогтносон, байгалийн баялаггүй, жижиг газар нутагтай, олон үндэстнээс бүрдсэн уг улс нь мэдлэгт суурилсан эдийн засаг, гадаадын хөрөнгө оруулалт татах чадвартай зохистой орчин, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжлийн стратегиа боловсруулсан нь энэхүү түүхэн амжилтад хүргэжээ.

Хүснэгт 1. Сингапур Улсын эдийн засгийн тоон үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Тоон мэдээлэл
ДНБ, 2024	547.4 тэрбум ам.доллар (Worldbank)
Нэг хүнд ногдох ДНБ, 2024	90,674.1 ам.доллар (Worldbank)
ДНБ-ий бодит өсөлт (жилийн өөрчлөлт), 2024	4.4% (SingStat)
Эдийн засгийн тэргүүлэх салбарууд (ДНБ-д эзлэх хувиар), 2024	1. Бөөний худалдаа 20.3% 2. Үйлдвэрлэл -17.3% 3. Санхүү, даатгал – 14.3% 4. Бусад үйлчилгээний салбар – 9.6% 5. Тээвэр, Хадгалалт – 9.1% (SingStat)
Инфляци, 2024	2.4% (SingStat)
ГШХО-ны дотогшлох урсгал (ДНБ-д эзлэх хувь), 2023	27.8% (Worldbank)
ГШХО-ийн гадагшлах урсгал (ДНБ-д эзлэх хувь), 2023	10.1% (Worldbank)
Ажиллах хүчний оролцооны түвшин (15-аас дээш насны нийт хүн амын %), 2024	68.2% (Singstat)
Ажилгүйдэл (нийт ажиллах хүчний %), 2024	2.1% (Singstat)
Зээлийн хүү, 2024	2.78% (Singstat)
ЖДҮ-ийн нийт тоо, 2024	354,600 (Singstat)

1965 онд 500 орчим ам.доллар байсан нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2024 оны байдлаар 88,000 ам.долларт хүрч 170 дахин өссөн байна. Энэхүү өсөлтийн суурь шалтгаан нь Сингапурын Засгийн газраас баримталсан зорилтот эдийн засгийн төлөвлөлт, боловсролын салбар дахь хөрөнгө оруулалт, экспортод суурилсан үйлдвэрлэл, стратегийн санхүүгийн бодлого төрийн зоримог оролцоо, институцийн чадавхи, салбар хоорондын уялдаа, эдийн засгийн төрөлжилт байв.

Сингапур улсын эдийн засаг хэд хэдэн шатлалыг туулан, стратегийн хувьд зорилтот салбаруудыг үе шаттайгаар төлөвлөн хөгжүүлсэн нь эдийн засгийн гол амжилт болж байна.

- *Аж үйлдвэрлэлээс өндөр технологи руу* – 1970-аад онд хөдөлмөр их шаардсан үйлдвэрлэлд анхаарч эхэлсэн бол 1990-ээд оноос электроник, нарийн инженерчлэл, биотехнологийн үйлдвэрлэлрүү шилжсэн. Өнөөдөр өндөр технологийн үйлдвэрлэл экспортын 40%-ийг бүрдүүлдэг.
- *Санхүүгийн үйлчилгээ* – Ази тив тэр дундаа Зүүн өмнөд Ази бүс нутгийн санхүүгийн төв болж, 100 гаруй олон улсын банк, 1000 гаруй хөрөнгө оруулалтын санг төвлөрүүлж, бүс нутгийн хөрөнгө оруулалтын гарц болж чаджээ. Санхүүгийн салбар нь ДНБ-ий 14%-ийг бүрдүүлж, 270,000 ажлын байр бий болгож байна
- *Худалдаа, ложистик* – Дэлхийн хамгийн ачаалалтай боомтуудын нэг бөгөөд худалдаа, экспорт нь эдийн засгийн гол хөдөлгөгч хүч хэвээр байна. PSA International зэрэг боомтын менежментийн компаниуд нь ухаалаг автоматжуулалт, AI суурьтай ложистикийн дэд бүтцийг нэвтрүүлнээр экспортын 80%-ийг бүрдүүлж байна.
- *Инновац ба мэдлэгт суурилсан эдийн засаг* – Сүүлийн 20 жилд тус улс нь инновац, гарааны бизнест эрчимтэй хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд 2021–2025 онд RISE (Research Incentive Scheme for Enterprises) хөтөлбөрт нийт 18.9 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж, судалгаа хөгжүүлэлтийн санхүүжилт ДНБ-ий 2%-иас давсан үзүүлэлттэй болсон байна.

Төрөөс хэрэгжүүлсэн “Research Incentive Scheme for Enterprises” (RISE) хөтөлбөр нь мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих шилжилтийн үндсэн тулгуур болсон ба зөвхөн судалгаанд биш, гарааны бизнесийг дэмжих венчур хөрөнгө оруулалт, судалгаа, хөгжүүлэлтийн төвүүд (R&D), их сургууль-аж үйлдвэрийн хамтын ажиллагаа зэргийг дэмжих бодлогоор дамжин эдийн засагт өндөр нөлөө үзүүлжээ.

Хөрөнгийн зах зээлийн хувьд Сингапур нь 1980-аад оноос эхлэн бүс нутгийн санхүүгийн төв болох стратегийг баримталж, хөрөнгө оруулалтын уян хатан бүтэц, ил тод, тогтвортой зохицуулалтын орчинг бүрдүүлсэн ба Сингапурын Хөрөнгийн Бирж (SGX) нь бүс нутгийн хэмжээний хамгийн идэвхтэй биржүүдийн нэг болж, нийт хөрөнгийн үнэлгээ нь 2024 онд 700 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүний зэрэгцээ санхүүгийн зохицуулагч байгууллага болох MAS (Monetary Authority of Singapore) нь финтек сэндбокс, токенжуулалт, дижитал хөрөнгийн зохицуулалтыг уян хатан, инновацид ээлтэй хэлбэрээр боловсруулж, шинэ технологийг хурдан нутагшуулах бодлого хэрэгжүүлж байна.

Гарааны бизнесийн экосистемийн хувьд Сингапур улс 2024 оны байдлаар дэлхийн хэмжээнд StartupBlink судалгаагаар 4-р байр, Startup Genome судалгаагаар 9-р байрт эрэмбэлэгдсэн нь тус улсын технологийн бизнесийн чадамж, хөрөнгө оруулалтын орчныг харуулж байна. Стартап компаниудад хийгдэж буй хөрөнгө оруулалт 2010 онд ердөө 1 тэрбум ам.доллар байсан бол 2024 онд 1200 гаруй хэлцэлд нийт 12 тэрбум ам.долларт хүрч өссөн бөгөөд Зүүн Өмнөд Ази бүс нутгийн хөрөнгө оруулалтын 60%-ийг дангаараа татах болсон байна.

Энэхүү өсөлтийн гол шалтгаан нь төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа бөгөөд "Startup SG Equity" зэрэг хөтөлбөрөөр дамжуулан Үндэсний хөрөнгө оруулалтын сан нь стратегийн чиглэл бүхий гарааны бизнесүүдэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчтай хамтран шууд хөрөнгө оруулдаг. Тухайлбал, 2024 онд энэ хөтөлбөрт 440 сая сингапур долларын нэмэлт санхүүжилт хийгдсэн нь олон улсын хөрөнгө оруулагчдын анхаарлыг улам татаж байна. Эдгээр хөрөнгө оруулалтын ихэнх нь дараах чиглэлүүдэд төвлөрч байна. Үүнд:

- *Финтек*: Ойролцоогоор 1200 финтек компани бүртгэлтэй, Зүүн өмнөд ази бүс нутгийн финтек төв болсон. Хөрөнгө оруулалтын дүн 2024 онд 4.4 тэрбум ам.доллар хүрсэн.
- *Хиймэл оюун ухаан болон deep-tech*: Хиймэл оюун ухааны судалгаанд зориулагдсан 500 сая ам.долларын хөтөлбөр, AI Strategy 2.0 хэрэгжиж эхэлсэн.
- *Уур амьсгалын өөрчлөлт*: Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн стартапуудыг дэмжих Climate Impact Fund нь 1.2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт татсан.
- *Биотехнологи ба эрүүл мэнд*: Geneo Hub, MedTech Innovation Programme зэрэг тусгай хөтөлбөрүүдээр дамжуулан амьдралын шинжлэх ухаанд төвлөрсөн хөгжүүлэлтийг өрнүүлж байна.
- *Web3 ба digital assets*: MAS-ийн зохицуулалтын дэмжлэгтэйгээр институцийн блокчейн болон токенжуулалт хөрөнгийн зах зээлд идэвхтэй хөгжиж байгаа.

Сингапур Улс нь төрийн тууштай бодлого, зохистой санхүүгийн зохицуулалт, боловсрол болон судалгаа, хөгжүүлэлтэд чиглэсэн хөрөнгө оруулалт, мөн олон улсын хамтын ажиллагааг уялдуулсан байдлаар дэлхийн стартап экосистемийн төвүүдийн нэг болж, инновацийн бодлогыг эдийн засгийн өсөлттэй уялдуулсан загвар улс болж чадсан юм. Энэхүү жишээ нь хөрөнгө оруулалтын сангууд, өндөр технологи, гарааны бизнесийг хөгжүүлэхэд нээлттэй бодлого, хариуцлагатай зохицуулалт, төр-хувийн хэвшлийн түншлэл, дижитал дэд бүтэц хосолсон нөхцөл байдал хэрхэн улс орны стратегийн хөгжлийг удирдаж болохыг

харуулсан чухал кейс болж байна. Сингапур Улсад инноваци, өндөр технологи, гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулалт хийх зорилготой дараах хөрөнгө оруулалтын сангууд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

Хүснэгт 2. Сингапур Улс дах инновац, өндөр технологи, гарааны бизнесүүдийг дэмжих зорилготой ХОС-ууд

Хөрөнгө оруулалтын сангийн нэр	Сангийн бүтэц	Хөрөнгийн хэмжээ AUM	Стартапд хөрөнгө оруулах хэлбэр	Хөрөнгө оруулалтын чиглэл	ХО хийсэн компаниуд
GIC (Government of Singapore Investment Corporation)	Sovereign wealth fund	\$744 тэрбум	VC сангуудаар дамжуулж шууд бусаар	Бүхий л салбар, чиглэлд тэнцвэртэй байдлаар хөрөнгө оруулдаг.	-
SEEDS Capital	Төрийн өмчим (Enterprise Singapore)	\$1.0 тэрбум	1:1, 2:1 харьцаагаар хувийн хэвшилтэй хамтарч, шууд	High-tech, deep-tech, healthtech, biotech, urban sustainability, innovation	~150 компани \$220 сая
SGInnovate	Төрийн өмчим (Startup SG Equity)	\$200 сая	Шууд бие даан хөрөнгө оруулдаг	Deep-tech startups working on AI, quantum computing, robotics, biotech	~70 компани \$200 сая
Temasek Holdings	Төрийн өмчим хөрөнгө оруулалтын н компани	\$339 тэрбум	Сангийн 6% хүртэлх хязгаарт шууд ба шууд бус хэлбэрээр	General technology, global innovation, sustainability, digital economy	~30 компани \$70 сая
Vertex Ventures	Төрийн өмчим (Temasek subsidiary)	\$1.5 тэрбум	Шууд, early stage	fintech, SaaS, healthtech, sustainability, deep-tech	~80 компани \$1.5 тэрбум
Golden Gate Ventures	Хувийн VC (SG-based)	\$250 сая	Шууд	Fintech, healthtech, agritech, consumer technology, B2B	~90 компани \$250 сая

		SaaS				
Monk's Hill Ventures	Хувийн VC	\$1 тэрбум	Шууд	General tech, logistics, SaaS	~20 компани	\$1 тэрбум
Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл						

SEEDS CAPITAL

Сингапурын Худалдаа үйлдвэрлэлийн яамны дэргэд инноваци, технологид суурилсан бизнесүүдийг хөгжүүлэх, ялангуяа жижиг, дунд бизнесүүдийг (ЖДБ) дэмжих үүрэгтэй **Enterprise Singapore** гэх агентлаг байдаг бөгөөд уг агентлагийн удирдлагад **SG Growth Capital** стратегийн хөрөнгө оруулалтын платформд үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү хөрөнгө оруулалтын платформ нь өөрийн **EDBI** (Economic Development Board Investments) болон **SEEDS Capital** хөрөнгө оруулалтын сангуудаар дамжуулан инноваци, технологи шингэсэн бизнесүүдэд хөрөнгө оруулалт хийдэг.

EDBI (Economic Development Board Investments) нь эдийн засгийн өсөлт, инновацын чадамжийг нэмэгдүүлэх стратегийн зорилгоор дотоод болон гадаадын технологи төвтэй, эрүүл мэнд, биотехнологи, дижитал шийдэл, хиймэл оюун ухаан зэрэг өндөр нөлөө бүхий салбаруудын компаниудад хөрөнгө оруулалт хийдэг. EDBI нь компаниудын өсөлтийн шатанд хөрөнгө оруулалт хийгээд зогсохгүй, Сингапурын бизнесийн орчинд нэвтрэхэд стратегийн зөвлөгөө, зах зээлийн дэмжлэг, түншлэл, технологийн хамтын ажиллагаа зэргээр тусалдаг.

SEEDS Capital нь эрт үе шатны буюу гарааны түвшний, өндөр өсөлтийн боломжтой, инноваци, технологид суурилсан стартап бизнесүүдийг дэмжих, хөрөнгө оруулалт хийх зорилготой төрийн өмчит хөрөнгө оруулалтын сан юм. Тус сангийн үйл ажиллагаа нь “**Төр хувийн хэвшлийн хамтарсан хөрөнгө оруулалт**” (co-investment) загвараар буюу хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчидтай (VC, angel хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалтын компаниуд) хамтарсан хөрөнгө оруулалт хийж, эрсдэл өндөртэй, инновацлаг бизнесүүдийг дэмжихэд чиглэдэг.

Одоогийн байдлаар тус байгууллага нь 150 орчим гарааны бизнесүүдэд 1.1 тэрбум ам.долларын хамтарсан хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд үүнээс 220 сая орчим ам.долларын хөрөнгө оруулалтыг өөрийн хөрөнгөөр хийсэн байна. Эдгээр хөрөнгө оруулалтууд нь олон улсын хөрөнгө оруулалтын сан, мэргэжлийн хөрөнгө оруулагчидтай хамтран хийгдсэн бөгөөд анхны хөрөнгө оруулалтаас хойш нэмэлт хөрөнгө татах чадамж бүхий бизнесүүдийг дэмжсэн нь онцлог юм. Эдгээр хөрөнгө оруулалт хийсэн гарааны бизнесүүдээс амжиттай

хэрэгжсэн жишээг дурдвал:

- **Shiok Meats – Хүнсний технологи**

Далайн гаралтай хиймэл мах үйлдвэрлэдэг гарааны бизнес бөгөөд SEEDS Capital болон Big Idea Ventures-ийн хамтарсан хөрөнгө оруулалтаар 30+ сая ам.долларын хөрөнгө оруулалт татаж, дэлхийд анхны хиймэл сам хорхой (shrimp)-г боловсруулж, зах зээлд нийлүүлж буй компани юм. Зах зээлийн үнэлгээ 70 сая ам.доллар хүрсэн байна.

- **Structo - 3D хэвлэх технологи**

Аж үйлдвэрийн зориулалттай дэвшилтэт 3D хэвлэгч машиг үйлдвэрлэдэг уг бизнес өдгөө эрүүл мэнд, шүдний салбарт өргөн хэрэглэгдэж байгаа бөгөөд Азийн томоохон 3D хэвлэлийн машины нийлүүлэгч болж өргөжин тэлсэн байна. Зах зээлийн үнэлгээ 60 сая ам.доллар хүрсэн.

- **Alchemy Foodtech - Хүнсний эрүүл мэнд**

Alchemy Fiber шинэ технологийн хүнс нь хоол хүнсний GI-глимексийн индекс бууруулж, цусан дахь сахарын хэмжээг хянах боломж бий болгосон. SEEDS Capital-аас хөрөнгө оруулалт авсны дараа олон улсын хүнсний корпорацуудтай түншлэл тогтоож, зах зээлийн үнэлгээ 25 сая ам.доллар хүрсэн.

Ингэснээр төрийн оролцоо гарааны бизнесийн эхэн үед илүү эрсдэл хүлээх бөгөөд хувийн хөрөнгө оруулагчдын итгэлийг татаж, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлдэг онцлогтой. Мөн түүнчлэн SEED capital нь гарааны бизнесийг зөвхөн санхүүгийн хувьд бус, экосистем, сүлжээ, хурдасгуур хөтөлбөрөөр дамжуулан цогцоор нь хөгжүүлдэг онцлогтой ба эрүүл мэнд, биотехнологи, хиймэл оюун ухаан, агротек, ногоон технологи, финтек зэрэг олон салбарт төвлөрч, Сингапурын инновацийн экосистемийг тэлэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай компанид бий болгоход нь туслах зорилготой хөрөнгө оруулалт хийдэг.

Хөрөнгө оруулалтын хэмжээ нь тухайн гарааны бизнесийн үйл ажиллагааны чиглэл, өсөлтийн потенциал, санхүүжилтийн хэрэгцээ зэргээс шалтгаалан \$250 мянгаас \$12 сая ам.доллар хүртэл байх бөгөөд энэхүү хөрөнгө оруулалтыг SEEDS Capital болон түүний түнш хөрөнгө оруулалтын сангуудын хамтын санхүүжилтээр үе шаттайгаар гарааны бизнесүүдэд олгодог байна. Энэхүү SEEDS Capital венчур капитал хөрөнгө оруулалтын сангийн төр хувийн хэвшил хамтарсан загвар нь Сингапурын эдийн засгийн шинэ суурь болох инноваци, технологийн өсөлтөд төрөөс чиглэсэн, ухаалаг дэмжлэг үзүүлж, хувийн хэвшлийг идэвхжүүлж, хөрөнгө оруулалтын эрсдэлийг хуваалцаж буй бөгөөд инноваци, өндөр технологи, гарааны бизнесийг дэмжих, хөрөнгө оруулах

сонгодог жишээ болж буй юм.

SG INNOVATIVE

Сингапурын Засгийн газраас 2016 онд үүсгэн байгуулсан **SG Innovate** нь гүн технологид (deep-tech) суурилсан инноваци шингэсэн гарааны бизнесүүдийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт хийх, хүний нөөц бүрдүүлэх зорилготой засгийн газрын агентлаг юм. Энэхүү байгууллага нь дээр дурдсан Enterprise Singapore болон National Research Foundation зэрэг төрийн байгууллагуудтай нягт уялдаа холбоотой ажилладаг бөгөөд **“Research, Innovation and Enterprise”** буюу RIE 2025 стратегийн хүрээнд шинжлэх ухаан, инженерчлэлийн суурьтай стартап экосистемийг бий болгож, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай инновацлаг компаниудыг бий болгохоор ажилладаг.

SG Innovate-ийн үйл ажиллагааны онцлог нь технологиос урган гарсан санаануудыг амжилттай бизнес болгон бойжуулахад бүх талаар — хөрөнгө оруулалт, мэргэжлийн зөвлөгөө, хүний нөөц, бизнесийн сүлжээ, R&D ба их сургуулийн хамтын ажиллагаа — дэмжлэг үзүүлдэгт оршдог. Гүн технологи нь нийтлэг венчур хөрөнгө оруулалттай харьцуулахад үйл ажиллагааны орлого бий болгох хугацаа урт, технологийн баталгаажуулалт өндөр учир төрийн ухаалаг оролцоо зайлшгүй шаардлагатай гэж үзсэн байна. SG Innovate нь дараах гурван үндсэн чиглэлд анхаарч, гарааны бизнесүүдийг хөгжүүлдэг:

- **Хөрөнгө оруулалт:** Шинжлэх ухаан, инженерчлэлд суурилсан гүн технологи хөгжүүлж буй гарааны бизнесүүдэд SGInnovate өөрийн хөрөнгө болон хамтрагч хөрөнгө оруулалтын сангуудтай хамтран эргэн төлөгдөх үнэт цаас (convertible note) болон өмчийн хамтарсан хөрөнгө оруулалт (co-investment) хэлбэрээр хөрөнгө оруулалт хийдэг. Хөрөнгө оруулалтын гол чиглэлд хиймэл оюун ухаан, биотехнологи, квант технологи, эрүүл мэндийн дэвшилтэт шийдэл, роботик, advanced manufacturing зэрэг багтана.
- **Бизнес бойжуулалт:** Шинжлэх ухааны салбарын шинэ санааг гарааны бизнес болгон бойжуулах үйл явцыг дэмждэг. Энэ хүрээнд их сургуулиуд, судалгааны байгууллагуудаас гарч ирж буй эрдэм шинжилгээний үр дүнг зах зээлд гаргахад нь тусалж, гарааны бизнес болгон хөгжүүлэх менторшип, зах зээлийн тест, баг бүрдүүлэлт зэрэгт цогц дэмжлэг үзүүлдэг.
- **Хүний нөөцийн хөгжил:** Гүн технологийн салбарын хүний нөөцийг бэлтгэх зорилготой Summation, PowerX зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Эдгээр нь инженер, дата судлаач, судалгааны ажилтан, бүтээгдэхүүн хөгжүүлэгч зэрэг мэргэжлээр суралцагч болон төгсөгчдийг стартап орчинд туршлага хуримтлуулах, улмаар шинэ бизнесүүдэд ажиллах боломжийг бүрдүүлдэг.

SG Innovate нь үүсгэн байгуулагдсанаас хойш гүн технологийн чиглэлээр үйл

ажиллагаа явуулдаг 100 гаруй гарааны бизнесүүдэд 200 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд эдгээрээс Aptorum Group, Hydroleap, H3 dynaics, SEPPURE, NDR Medical Technology компаниуд зах зээлд амжилттай нэвтэрч, цаашдын хөрөнгө оруулалт татах, олон улсын зах зээлд гарч амжилттай үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна.

SGInnovate-ийн хөрөнгө оруулалтын загвар нь SEEDS Capital-ийн нэгэн адил төр-хувийн хэвшлийн хамтарсан хөрөнгө оруулалт (co-investment) загварт үндэслэдэг. Хөрөнгө оруулалтын хэмжээ нь стартапын хөгжлийн шат, технологийн төвшин, зах зээлийн боломж, багийн чадамжаас хамааран ялгаатай хэдий ч дараах чиг хандлагатай байна. Үүнд:

Хүснэгт 3. SG Innovate-ийн хөрөнгө оруулалтын ерөнхий мэдээлэл

Хөрөнгө оруулалтын үе шат	Хөрөнгө хэмжээ	Хөрөнгө оруулалтын харьцаа Төр : Хувийн хэвшил
Эрт үе шат (Seed stage, early stage)	\$250 мянга хүртэл	7:3
Хөгжлийн үе шат (Series A-ээс D хүртэлх)	\$1-3 сая хүртэл	1:1
Гүн технологийн стартап	\$5-7 сая хүртэл	1:2, 1:3

SG Innovate нь Сингапурын төрөөс гүн технологи (deep-tech) чиглэлээр ухаалаг хөрөнгө оруулалт хийж, шинжлэх ухааны судалгааг бизнес болгох боломжийг бүтээж буй экосистем хөгжүүлэгч, венчур капитал хөрөнгө оруулалтын сан юм. Энэ нь зөвхөн санхүүгийн дэмжлэг бус, стартап хөгжүүлэх бүх шатны дэмжлэг, хүний нөөц, R&D-тэй холбох, хөрөнгө оруулагчдын сүлжээ зэргийг хослуулан инновацлаг, өсөлттэй компаниудыг бий болгож буйгаараа онцлог юм. SEEDS Capital-ийн хамт SG Innovate нь Сингапурын инновац, технологи суурьтай гарааны бизнесийг хөгжүүлэх, технологийн эдийн засгийн үндэс суурийг бүрдүүлэгч хоёр үндсэн тулгуур болсон байна.

3.3 Израил улсын гарааны бизнесийн хөгжил ба өнөөгийн нөхцөл байдал

Израил улс нь байгалийн баялаг багатай, жижиг газар нутагтай, хүн амын тоо харьцангуй цөөн ч гэлээ дэлхийн хамгийн инновацлаг, технологид суурилсан эдийн засагтай улс орны нэг болж чадсан онцгой жишээ юм. Энэхүү амжилтын үндэс нь төрийн зоримог бодлого, гүн технологи (deep-tech)-ийг дэмжсэн венчур хөрөнгө оруулалтын оновчтой загвар, судалгаа хөгжүүлэлтэд чиглэсэн хөрөнгө оруулалт, мөн боловсролын системийн чанар, үндэсний аюулгүй байдал, бизнесийн орчны харилцан уялдаанд оршиж байна. Израилийн Засгийн газар нь ДНБ-ий 5.6 хувийг судалгаа, хөгжүүлэлт (R&D)-д зарцуулж байгаа нь дэлхийд хамгийн өндөр үзүүлэлтэд тооцогдож, мэдлэгт суурилсан эдийн засгийг тууштай дэмжиж байгааг илтгэнэ.

Хүснэгт 4. Израил Улсын эдийн засгийн тоон үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Тоон мэдээлэл
ДНБ, 2024	540.4 тэрбум ам.доллар (Worldbank)
Нэг хүнд ногдох ДНБ, 2024	54,176.7 ам.доллар (Worldbank)
ДНБ-ий бодит өсөлт (жилийн өөрчлөлт), 2024	2.9% (IsraelStat)
Эдийн засгийн тэргүүлэх салбарууд (ДНБ-д эзлэх хувиар), 2024	- Бөөний худалдаа 20.3% - Үйлдвэрлэл -17.3% - Санхүү, даатгал – 14.3% - Бусад үйлчилгээний салбар – 9.6% - Тээвэр, Хадгалалт – 9.1% (SingStat)
Инфляци, 2024	2.4% (SingStat)
ГШХО-ны дотогшлох урсгал (ДНБ-д эзлэх хувь), 2023	27.8% (Worldbank)
ГШХО-ны гадагшлах урсгал (ДНБ-д эзлэх хувь), 2023	10.1% (Worldbank)
Ажиллах хүчний оролцооны түвшин (15-аас дээш насны нийт хүн амын %), 2024	68.2% (Singstat)
Ажилгүйдэл (нийт ажиллах хүчний %), 2024	2.1% (Singstat)
Зээлийн хүү, 2024	2.78% (Singstat)
ЖДҮ-ийн нийт тоо, 2024	354,600 (Singstat)

1990-ээд оноос Израил улс нь технологи, инновацад суурилсан эдийн засагт шилжихдээ төр-хувийн хэвшлийн хамтарсан хөрөнгө оруулалтын механизмыг нэвтрүүлж, инновацийн экосистемийг бүхэлд нь хөгжүүлэх бодлого хэрэгжүүлжээ. Энэхүү бодлогын суурь нь 1993 онд хэрэгжүүлсэн “Yozma Program” хөтөлбөр бөгөөд төрөөс анх 100 сая ам.долларын хөрөнгө бүхий хөрөнгө оруулалтын сан байгуулж, хувийн хөрөнгө оруулалтын сангуудтай хамтран технологи, инноваци суурьтай гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн. Хамгийн онцлууштай нь тухайн хөрөнгө оруулсан

стартап амжилттай болсон тохиолдолд хувийн хэвшил төрийн эзэмшлийг бүрэн худалдан авах боломж олгодог уян хатан механизмаар венчур хөрөнгө оруулалтын экосистемийг хурдацтай хөгжүүлжээ. Yozma Group нь уг хөтөлбөрөөс үүсэж, өдгөө олон улсын түвшний хөрөнгө оруулалтын сан болж хөгжсөн бөгөөд 50 гаруй стартап хөрөнгө оруулсан ба үүнээс 20 гаруй нь амжилттай болж, хөрөнгийн бирж дээр IPO хийж нээлттэй компани болсон байна. Өнөөдөр Израил улсад 9,000 гаруй стартап бүртгэлтэй байгаагаас гадна хүн амын тоотой харьцуулахад хамгийн өндөр стартап нягтаршилтай улс болж, дэлхийд "Startup Nation" хэмээн өргөмжлөгдөх болсон юм.

Израилийн венчур хөрөнгө оруулалтын экосистемд төрийн венчур хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэгч үндсэн байгууллага бол Israel Innovation Authority (IIA) юм. Тус байгууллага нь жил бүр ойролцоогоор 500 сая ам.долларын төсөвтэйгөөр 1,400 гаруй төсөлд санхүүжилт олгодог бөгөөд гүн технологид суурилсан стартапууд, их сургуулиуд, судалгааны байгууллагууд, R&D төвүүдийг санхүүжүүлэх, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, олон улсын хамтын ажиллагааг уялдуулах үүрэгтэй. IIA нь судалгаа хөгжүүлэлтийн төсөл, гүн технологийн стартапуудад хөрөнгө оруулалт хийхдээ хувийн хөрөнгө оруулагчидтай хамтарсан буюу төр-хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын загвар (co-investment model)-ыг ашигладаг. Энэхүү загварын дагуу эрт үе шатны хөрөнгө оруулалтад төрийн оролцоо илүү их буюу 2:1, хөгжлийн шатанд 1:1, харин deep-tech буюу технологийн өндөр эрсдэлтэй бизнесүүдэд төр 3:1 харьцаагаар хөрөнгө оруулдаг. Хамгийн онцлог тал нь тухайн стартап бүтэлгүйтсэн тохиолдолд төр эрсдэл хүлээж, амжилттай болсон тохиолдолд төрийн эзэмшлийг хөрөнгө оруулагч худалдан авч, зах зээлд нээлттэй хэлбэрээр шилждэг нь хувийн хэвшлийн идэвхийг нэмэгдүүлдэг.

Израилийн венчур хөрөнгө оруулалтын зах зээлд төрийн хөрөнгөөр үүсгэн байгуулагдсан ч өдгөө хувийн салбарт бүрэн шилжсэн Yozma Group, үндэсний хэмжээний хөрөнгө оруулалтын платформ болсон OurCrowd, Pitango VC, Jerusalem Venture Partners зэрэг олон улсын нэр хүнд бүхий венчур хөрөнгө оруулалтын сангууд үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр сангуудын хөрөнгийн хэмжээ нь 250 саяас 2.8 тэрбум ам.долларт хүрч, Израилийн стартап экосистемийг олон улсын зах зээлд амжилттай гаргахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Жишээлбэл, OurCrowd нь дижитал платформоор дамжуулан олон нийтэд хөрөнгө оруулах боломж олгодог анхны crowd-investment хэлбэрийн сан болж, нийт 400 гаруй стартап 2 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.

Салбарын хувьд Израил Улс нь гүн технологи буюу deep-tech чиглэлд хамгийн хүчтэй төвлөрдөг. Үүнд хиймэл оюун ухаан, роботикс, компьютер хараа, квант технологи, биотехнологи, медтек, хөдөө аж ахуйн инновац, уур амьсгалын технологи зэрэг салбарууд багтдаг. Израилийн кибер аюулгүй байдлын салбар

нь дэлхийд тэргүүлж байгаа бөгөөд тус улс нь дэлхийн хэмжээнд нийт кибер стартапын 40 орчим хувийг дангаараа эзэлж байна. Мөн агротехнологийн салбарт Netafim, CropX зэрэг усалгааны ухаалаг шийдэл бүхий стартапууд нь дэлхийн зах зээлд амжилттай байр суурь эзэлж чадсан жишээ юм. Биотехнологийн чиглэлд Genetika+, Insightec зэрэг компаниуд нь эрүүл мэндийн шинэ технологи боловсруулан, олон улсын хөрөнгө оруулалт татаж чадсан байна.

Израилийн инновацын экосистемийн өөр нэг чухал бүрэлдэхүүн нь их сургууль, судалгааны төвүүдийн судалгаа хөгжүүлэлтийн үр дүнг бизнес болгох механизмууд юм. Энэ хүрээнд Technology Transfer Offices (TTOs) буюу их сургуулийн дэргэдэх технологи дамжуулах төвүүд идэвхтэй ажиллаж, судлаачдын бүтээлийг хувийн хэвшилд дамжуулах, патентжуулах, стартап үүсгэх процессыг дэмждэг. Мөн IIA болон Европын холбоо, АНУ, Ази-Номхон далайн орнуудтай хамтарсан R&D түншлэлийн сангуудыг хэрэгжүүлж, олон улсын хамтын ажиллагаа, гадаадын хөрөнгө оруулалтыг татах орчныг бүрдүүлж байна.

Энэхүү бодлогын хүрээнд төр нь зөвхөн санхүүгийн дэмжлэг үзүүлэх бус, экосистемийн бүх оролцогчдыг уялдуулсан, стратегийн удирдлагатай, уян хатан, эрсдэлийг хувийн хэвшилтэй хамтран хуваалцах механизм бүрдүүлж чадсанаараа онцлог юм. Хамгийн гол нь венчур хөрөнгө оруулалт нь төрийн зоримог бодлого, зөв институцийн бүтэц, судалгаа ба үйлдвэрлэлийн уялдаа, өндөр ур чадвартай мэргэжлийн хүч, нээлттэй олон улсын орчны хослолын дүнд Израил улсын эдийн засгийн хөгжлийн гол тулгуур болсон байна.

Израилийн венчур хөрөнгө оруулалтын амжилттай сангуудын нэг бол Pitango VC юм. Энэхүү сан нь 1993 онд үүсгэн байгуулагдсан ба өдгөө 2.8 тэрбум ам.долларын хөрөнгө удирдаж, нийт 250 гаруй стартапт хөрөнгө оруулалт хийгээд байна. Fintech, enterprise software, AI зэрэг салбарт анхны хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд хөрөнгө оруулалт нь үргэлжлэн өсөлтийн шат хүртэл хамардаг.

Мөн Jerusalem Venture Partners (JVP) нь 1993 онд байгуулагдсан бөгөөд 1.6 тэрбум ам.долларын хөрөнгө удирдаж, 160 гаруй стартапт хөрөнгө оруулсан. Тус сан нь кибер аюулгүй байдал, медиа технологи зэрэг чиглэлээр дагнасан хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд хөрөнгө оруулалтынхаа хүрээнд түншлэл, кластер хэлбэрийн инкубатор, акселератор хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

OurCrowd нь 2013 онд байгуулагдсан бөгөөд crowd-investment загварыг нэвтрүүлсэн анхны платформ хэлбэрийн хөрөнгө оруулалтын сан юм. Энэхүү платформ нь хувь хүн, жижиг хөрөнгө оруулагчдад стартапт хөрөнгө оруулах боломж олгодог бөгөөд нийт 400 гаруй стартапт 2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн. OurCrowd нь 195 улс орны 225,000 гаруй гишүүн

хөрөнгө оруулагчтай, хөрөнгө оруулалтыг урьдчилсан сонгон шалгаруулалт, due diligence хийсний дараа нийтэд нээлттэй болгодог системтэй. Тус сан нь deep-tech, agritech, cleantech зэрэг олон чиглэлд хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд гарааны бизнесүүдэд стратегийн зөвлөмж, зах зээлийн хандалт, дараагийн шатны хөрөнгө татах чиглэлээр дэмжлэг үзүүлдэг.

Израилийн венчур хөрөнгө оруулалтын экосистемийн онцлог нь төрөөс зөвхөн санхүүжилт үзүүлэх бус, мөн эрсдэлийг хувийн хэвшилтэй хамтран үүрэлцэх замаар хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, стартапыг хөгжүүлэх бүх шатанд уялдаа холбоотой дэмжлэг үзүүлж буй явдал юм. Энэхүү ухаалаг, нээлттэй, зоригтой бодлого нь Израилийг дэлхийн стартапын тэргүүлэх төвүүдийн нэг болгосон юм. Израилийн венчур хөрөнгө оруулалт болон инновацын төрийн бодлогын амжилт дараах үндсэн тулгуур хүчин зүйлс дээр суурилсан байна:

- 1. R&D-д өндөр хувиар хөрөнгө оруулах төрийн бодлого:** Израил улс ДНБ-ий 5.6 хувийг судалгаа, хөгжүүлэлтэд (R&D) зарцуулж байгаа нь дэлхийд тэргүүлэх түвшинд тооцогддог. Судалгаа шинжилгээ нь инновацын суурь ба технологийн стартап үүсэх үндэс гэж үзэн, төрөөс их дээд сургуулиуд, судалгааны хүрээлэн, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг бодлогоор урамшуулж, тогтмол хөрөнгө оруулалт хийдэг. Энэхүү өндөр хөрөнгө оруулалт нь шинжлэх ухааны шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлж, стартапуудын технологийн суурийг бэхжүүлдэг.
- 2. Гүн технологи, удаан хугацааны өгөөжтэй бизнесийг дэмжих зоримог сангууд:** Deep-tech буюу судалгаа, инженерчлэл, өндөр мэдлэгт суурилсан технологиудыг дэмжих нь богино хугацаанд шууд ашиг өгдөггүй ч улс орны инновацын чадамж, стратегийн давуу талыг бий болгодог. Израилд үйл ажиллагаа явуулж буй Pitango VC, JVP, OurCrowd зэрэг сангууд нь хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал, биотехнологи, хөдөө аж ахуйн инновац, квант технологи зэрэг салбарт анхны шатнаас нь хөрөнгө оруулж, тэдгээрийг өсөлтийн шат руу хүргэдэг урт хугацааны стратеги баримталдаг. Ийнхүү төрийн урамшуулал, зах зээлийн механизм хоёр уялдаж deep-tech стартапуудыг бойжуулах суурь нөхцөл бүрджээ.
- 3. Хөрөнгө оруулагчдад эрсдэл бууруулсан хамтарсан хөрөнгө оруулалтын ухаалаг загвар:** Төрөөс хөрөнгө оруулалт хийхдээ хувийн хөрөнгө оруулагчтай хамтран (co-investment model) ажиллаж, стартап бүтэлгүйтсэн тохиолдолд төр эрсдэлийг хүлээдэг, харин амжилттай болвол төрийн эзэмшлийг хувийн хөрөнгө оруулагч худалдаж авах боломжтой уян хатан системийг нэвтрүүлсэн. Энэ нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, эрт үе шатны хөрөнгө оруулалтыг идэвхжүүлсэн. ИА-ийн хэрэгжүүлдэг энэхүү загвар нь зөвхөн санхүүжилт биш, мөн стратегийн дэмжлэг, хяналт,

зөвлөгөөг цогцоор нь багтаадаг.

4. **Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах нээлттэй орчин:** Израил улс нь гадаадын хөрөнгө оруулалтад ээлтэй, ил тод, зохицуулалт сайтай орчинг бүрдүүлсэн. Олон улсын венчур сангууд, томоохон технологийн компаниуд (Google, Intel, Microsoft зэрэг) тус улсад R&D төв болон хөрөнгө оруулалтын нэгж байгуулсан нь энэхүү итгэлцлийн баталгаа юм. Мөн олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Европын Холбоо, АНУ, Азийн орнуудтай хамтарсан R&D, инновацын сангууд ажиллаж, Израилийг технологийн глобал сүлжээний нэг хэсэг болгож байна.
5. **Инновацын экосистемийн бүх оролцогчдыг холбосон уялдаа холбоо бүхий бүтэц:** Израилийн инновацын систем нь их дээд сургууль, судалгааны төв, төрийн агентлаг, венчур хөрөнгө оруулалтын сан, технологи дамжуулах алба (ТТО), акселератор, инкубатор, олон улсын түншүүд, зах зээл зэрэг бүх оролцогчдыг уялдуулах бүтэцтэй хөгжсөн. Энэ нь стартапуудыг зөвхөн хөрөнгөөр бус, мэдлэг, зах зээл, хүний нөөц, хуулийн зохицуулалт, бизнесийн зөвлөгөө зэрэг бүхий л талаас дэмждэг “цогц” системийг бүрдүүлжээ.


БҮЛЭГ 4. МОНГОЛ УЛСЫН ГАРААНЫ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

4.1 Монголын мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн хөгжил олон улсад

Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-аас 2 жил тутамд гаргадаг "Цахим засаглалын хөгжлийн индекс"-ээр Монгол Улс 2022 онд нийт 193 орноос 74 дүгээр байранд орж байсан бол 2024 онд 46 дугаар байранд эрэмбэлэгдэж, өмнөх онтой харьцуулахад 28 байр урагшилсан.

Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас жил бүр гаргадаг "Дэлхийн инновацын индекс"-ээр 2024 онд 133 улсаас 67-р байранд жагсаж, 1 байр урагшилсан. Инновацын дүр зураглалыг аль болох бүрэн дүүрэн гаргахаар зорьдог тус индекс нь улс төрийн орчин, боловсрол, дэд бүтэц, мэдлэгийн бүтээн байгуулалт зэрэг 80 орчим үзүүлэлтийг багтаадаг ба манай улсын хувьд хүмүүн капитал (86), дэд бүтэц (73), бизнесийн боловсронгуй байдал (61) зэрэг дундаж үзүүлэлттэй хэдий ч, хамгийн доогуур жагсаж буй үзүүлэлт нь зах зээлийн боловсронгуй байдал буюу зээл, хөрөнгө оруулалт, худалдаа, төрөлжилт, зах зээлийн цар хүрээгээрээ 106 дугаарт жагсаж байгаа бөгөөд энэ дэд үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад даруй 5 байраар ухарчээ.

Зураг 1. Дэлхийн инновацын индексийн үзүүлэлт



Энэ нь манай улс инновац, нэмүү өртөг шингэсэн бизнес эрхлэлтийн хууль эрх зүйн таатай орчин бүрдээгүй, санхүүжилт хөрөнгө оруулалт хангалттай бус байгаатай холбон ойлгож болох юм.

СтартапБлинкийн “Дэлхийн гарааны бизнесийн экосистемийн индекс 2025” тайлангаас харахад Монгол Улс 0.849 оноогоор нийт 100 орноос 80 дугаар байранд эрэмбэлэгдэж өнгөрсөн оноос 1 байраар урагшилжээ. Уг үзүүлэлтийг бусад улстай харьцуулахад Казахстанас 0.102, Вьетнамаас 1.848, Эстониос 22.075 оноогоор тус тус хоцорсон үзүүлэлттэй ч Ази, номхон далайн бүсэд 18 дугаар байранд харин Зүүн Азид эхний 5-д орсон байна. Түүнчлэн 2024 онд нийт 3.6 сая ам.долларын санхүүжилт татсан талаар уг тайланд дурджээ³.

Дэлхийн 190 сонгогдсон хотуудад үндэсний болон бүс нутгийн түвшинд бизнес эрхлэлтийн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийг бодитойгоор хэмждэг Дэлхийн банкны “Бизнес эрхлэлт”-ийн 2020 оны тайланд манай улс 81-р байранд жагссан. Уг тайлан нь шинэчлэгдэн “Бизнест бэлэн” гэгдэх болсон хэдий ч манай улсад уг тайланд ороогүй байна.

Дэлхийн өрсөлдөх чадварын төв болон Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс хамтран гаргадаг “Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан-2024”-т Монгол Улс тайланд хамрагдсан 67 улсаас 61-д эрэмбэлэгдэж, өмнөх оноос 10.74 оноогоор нэмэгдэж 1 эрэмбэ өссөн. Тус тайланг 67 улсын өрсөлдөх чадварыг эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн байгууллагын ашигт ажиллагаа, дэд бүтэц гэсэн үндсэн 4 хүчин зүйл, 20 дэд бүлэг, нийт 336 шалгуур үзүүлэлтээр харьцуулан хэмжсэн, хамгийн дэлгэрэнгүй, нарийвчилсан судалгаа юм. Манай улсын эрэмбэ, онооны хувьд сайжрахад эдийн засгийн эерэг үзүүлэлтүүд, институт болон нийгмийн үзүүлэлтүүд сайжирсан зэрэг түлхүү нөлөөлсөн бол бизнес эрхлэх орчин, дэд бүтцийн үзүүлэлтүүд өрсөлдөх чадварыг хойш татсаар байна. Түүнчлэн эдийн засгийн тамир тэнхээ, засаглал болон бизнесийн байгууллагуудын үр ашигт ажиллагаа бүлгүүд эрэмбэ урагшилж харин дэд бүтцийн хувьд ухарсан байна⁴.

4.2 Гарааны бизнесийн экосистемийн төлөв байдал


Монголын гарааны бизнесийн экосистем хурдацтай өргөжиж, хүлээн зөвшөөрөгдсөн гарааны бизнес эрхлэгчдийн тоо 2023 онд 158 байсан бол 2025 онд бараг 2 дахин

³ Global Startup Ecosystem Index 2025

⁴ Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан 2024, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

нэмэгдэж энэ тоо 293 болжээ. Энэхүү өсөлт нь ялангуяа финтек, харилцаа холбоо, цахим засаглалын платформуудад идэвхтэй бизнес эрхлэх бааз суурь болж, энтрепренёруудын эрч хүч нэмэгдэж, инновацад тулгуурласан өсөлтийн загваруудыг нийгэмд өргөнөөр хүлээн зөвшөөрч байгааг харуулж байгаа ч Монголын экосистемд цар хүрээ, санхүүжилт, харагдах байдлын хувьд байнгын саад бэрхшээл тулгарч байна. Өөрөөр хэлбэл Монголын гарааны бизнесийн экосистемийн хөгжлийг бүс нутгийн улс орнуудтай харьцуулбал эхний үе шатандаа явж байна.

Зураг 2. Гарааны бизнес эрхлэгчдийн өсөлт⁵



Манай улс сүүлийн жилүүдэд цахим шилжилтийг эрчимтэй хийж эхлэн, олон төсөл, арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлсэн. Эдгээрийн нэг нь төрийн үйлчилгээний нэгдсэн систем “E-Mongolia” платформыг хөгжүүлж, 2020 онд хэрэглээнд амжилттай нэвтрүүлснээс гадна нийслэл Улаанбаатар хотод хүн амын дийлэнх нь амьдардаг бөгөөд гарааны бизнесийг дэмжигч хэд хэдэн байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд shopru.mn, TomYo Edtech, Чимэгэ зэрэг гарааны бизнесүүд амжилттай үйл ажиллагаагаа эрхэлж байна.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-аас 2024 онд хийсэн “Монголын гарааны бизнесийн экосистем” судалгаанаас харахад гарааны компаниуд

⁵ Startup ecosystem maps 2025

нь гол төлөв боловсролын технологи (36%) байгаа бол үүний дараа хиймэл оюун, их өгөгдөл ба аналитик (26%), зар сурталчилгаа/маркетингийн технологи (25%)-ийн дэд салбар орж байна. Боловсролын эрэлт хэрэгцээ өндөр байгаа учраас Боловсролын технологи (тоогоор)-ийн гарааны компаниуд тэргүүлж байна. Харин финтек болон блокчэйнийн технологийн чиглэл орлогоор тэргүүлж байна.

Зураг 3. Гарааны компаниудын бүтэц (дэд салбараар)



Монголын гарааны бизнес эрхлэгчдийн экосистемд биет дэд бүтэц, санхүүгийн хүртээмжтэй холбоотой олон бэрхшээл тулгарсаар байна. Юутай ч Засгийн газар “бизнес эрхлэлтийн өсөлтийг идэвхтэй дэмжиж, инновацыг улс орны өсөлтийн томоохон хөдөлгүүр гэж нэн тэргүүнд тавьж байгаа” талаар уг тайланд онцолжээ.

Түүнчлэн Казахстан, Узбекистан 314 сая ам.доллар, 354 сая ам.долларыг гарааны бизнест зарцуулсан бол Вьетнам 2023 онд 529 сая ам.доллар татсан байна. Дэлхийд нэр хүндтэй инновацын экосистемтэй Эстони улс 2024 онд 348.2 сая ам.долларын хөрөнгө босгож, төрийн дэмжлэг, дижитал төлөвшсөн бизнесийн орчныг дэмжсэн⁶.

Хүснэгт 5. Гарааны бизнесийн экосистемийн харьцуулалт

⁶ Global Startup Ecosystem Index 2025

Улсын нэр	Гарааны компанийн тоо	Венчур хөрөнгө оруулалт	Голлон анхаарч буй салбар
Монгол	293	N/A	Финтек, Харилцаа холбоо, Цахим засаг, Иргэний бүртгэл, Программ хангамж
Казакстан	1000	314 сая ам.дол	Финтек, Боловсрол, Цахим худалдаа, Төлбөрийн аппликейшн
Узбекстан	749	354 сая ам.дол	Хиймэл оюун, Нийгмийн сүлжээ, Тоглоом, Зар сурталчилгаа, Финтек
Вьетнам	3000	529 сая ам.дол	Цахим худалдаа, SaaS, Төлбөрийн хэрэгсэл, Гар утасны аппликейшн, Борлуулалтын зах зээл
Эстони	1452	348.2 сая ам.дол	Финтек, Эрчим хүч, Аюулгүй байдал, Хүнсний үйлдвэрлэл, Маркетинг

Анх 2003 онд “Мэдээллийн технологийн салбарын шинэ санаа, санаачилгыг бүтээгдэхүүн, үйлчилгээ болгох, шинэ технологид суурилсан бизнесийг хөгжүүлэхээр шинээр байгуулагдаж буй залуу компаниудад урамшууллын таатай орчин бүрдүүлэн ололт амжилт, өсөлтийг нь хурдасгахад цаг хугацааны болон хөрөнгө оруулалт, менежментийн иж бүрэн дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд тогтворжсон, дотоод гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай компани болох эхний чадавхтай болтол нь торниулан бойжуулах” зорилгоор Мэдээлэл технологийн үндэсний парк (МТҮП)-ыг байгуулж, программ хангамжийн чиглэлээр бизнес эрхлэгчдийг элсүүлэх бодлого барьж, “Мэдээллийн технологийн инкубаторт элсэх иргэн ба компаниудыг сонгон шалгаруулах журам” боловсруулан баталсан.

Тус журам батлагдсанаар 2003 оны 9 сард инкубаторын анхны элсэлтийг зохион байгуулж, нийт 23 аж ахуйн нэгж, хувь хүн хүсэлт гаргаснаас, 11 аж ахуйн нэгж болон 2 иргэнийг сонгон шалгаруулж элсүүлсэн. 2025 оны байдлаар инкубаторт бойжиж буй 22 компанийн үйл ажиллагааны чиглэлийн хувьд программ хангамж ба технологийн хөгжүүлэлт 32%, хиймэл оюун ба зүйлсийн интернэт 23%, виртуал болон дижитал контент 18%, бусад үйлчилгээ 27% байна.

Сүүлийн жилүүдэд технологийн гарааны компаниуд блокчэйн, өргөтгөсөн бодит байдал (AR), виртуал бодит байдал (VR), зүйлсийн интернет (IoT), хиймэл оюун зэрэг дэвшилтэт салбарт хүчээ үзэж байгаа нь Монгол Улсын инновацын хөгжил өргөжиж, дотоодын бизнес эрхлэгчид бүс нутгийн болон дэлхийн зах зээлд нэвтрэх эрмэлзэлтэй болж байгааг харуулж байна.

4.3 Бодлого, зохицуулалт, хууль эрх зүйн орчин

Өнөөгийн мэдлэгийн эдийн засагт инновац болон мэдээллийн технологийн үйлдвэрлэл нь улс орны эдийн засгийн хөгжлийн тулгуур болж байна. Гарааны буюу технологийн гарааны бизнес нь хөдөлмөрийн зах зээлд шинэ ажлын байр бий болгож, бизнесийн орчинд эрчимтэй өрсөлдөөн үүсгэж буйгаараа орчин үеийн эдийн засгийн хамгийн чухал ойлголт юм. Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд мэдлэгийн эдийн засгийг амжилттай хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг хурдасгах, инновацийн үйл ажиллагаанд оролцогчдын үр дүнтэй нягт хамтын ажиллагааг өргөжүүлэн, хөгжүүлж, инновац, өндөр технологид суурилсан, нэмүү өртөг шингээсэн, мэдлэгт суурилсан мэдээллийн технологийн үйлдвэрлэл болон үр ашигтай энтрепренершипыг дэмжих тогтолцоог бүрдүүлэхэд сүүлийн жилүүдэд ихээхэн анхаарч байна.

Хүснэгт 6. Холбогдох хууль, журам

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Зорилго	Хүчинтэй эсэх
1	Инновацийн тухай хууль	2012.05.22	Энэ хуулийн зорилт нь инновацийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, төрийн дэмжлэг, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулан эзэмших, ашиглах, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Хүчинтэй
2	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	2024.06.05	Энэ хуулийн зорилт нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийг дэмжих, санхүүжүүлэх эх үүсвэрийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн эдийн	Хүчинтэй

			засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх цахим эдийн засгийг дэмжихэд оршино	
3	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хуулийн тухай	2019.06.06	- Энэ хуулийн зорилго нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдгээрийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэхэд чиглэнэ. - Энэ хуулийн зорилт нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээнд үзүүлэх төрийн дэмжлэгийн хамрах хүрээ, хэлбэр, удирдлага, зохицуулалтын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Хүчинтэй
4	Хөрөнгө оруулалтын тухай хууль	2013.10.03	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгааг тогтоох, хөрөнгө оруулалтыг дэмжих, тогтворжуулах татварын орчныг тогтоох, хөрөнгө оруулалтын талаар төрийн байгууллагын эрх хэмжээ, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлох болон хөрөнгө оруулалттай холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.	Хүчинтэй
5	Оюуны өмчийн тухай хууль	2020.01.23	Энэ хуулийн зорилт нь оюуны өмчийн эрхээр хамгаалагдах бүтээл, оюуны өмчийг хамгаалах зарчим, оюуны өмчийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тогтоох, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахыг дэмжихтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.	Хүчинтэй

6	Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль	2012.02.10	Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Хүчинтэй
7	Инновацийн төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх, Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид Грант олгох журам	2025 оны 224-р тогтоол	Энэхүү журмаар инновацийн төсөл шалгаруулах, грант олгох, хэрэгжилтэд нь хяналт тавих, үр дүнг тооцох үйл ажиллагааг зохицуулна.	Хүчинтэй
8	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль	2024.05.16	- Энэ хуулийн зорилго нь мэдлэгт суурилсан эдийн засаг, нийгмийн чиг баримжаа бүхий шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх замаар үндэсний өрсөлдөх чадварыг сайжруулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино. - Энэ хуулийн зорилт нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, уг үйл ажиллагааны бодлого, төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт, хувийн хэвшлийн оролцоо, төрийн дэмжлэг, санхүүжилтийн эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Хүчинтэй

9	Шинжлэх ухаан, технологийн сангийн дүрэм	2019 оны 50-р тогтоол	Шинжлэх ухаан, технологийн сан (цаашид "Сан" гэх)-гийн зорилго нь шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилт олгох, зарцуулсан хөрөнгийн ашиглалтад хяналт тавих, нэгтгэн тайлагнахад оршино.	Хүчинтэй

Инновацийн тухай хууль

Монголд гарааны бизнесийг 2012 онд батлагдсан Инновацийн тухай хуульд тодорхойлсон боловч энэ хуульд тодорхойлсон томъёолол нь технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед хуучирсан, шинэчлэн найруулах шаардлагатай, хязгаарлагдмал агуулгатай гэдгийг гарааны бизнес эрхлэгчид, судалгаа шинжилгээ болон төрийн байгууллагууд хүлээн зөвшөөрч байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Түүнчлэн гарааны бизнес гэсэн ойлголтыг захиргааны болон хууль тогтоомжийн түвшинд шинээр орж ирж буй бизнестэй андуурах явдал байдаг бөгөөд цаашид уг томъёоллыг олон улсын жишигт нийцүүлэх нь зүйтэй байна. Мөн гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэхэд засгийн газрын үүргийг тодорхой болгож, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, технологийн гарааны бизнесийн экосистемийг дэмжих зорилгоор тусгайлсан хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Инновацийн тухай хуулийн 16.4.1-д заасны дагуу технологи дамжуулах төв, эсхүл хамтын оффист гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид төрөөс татварын дэмжлэг үзүүлэх, түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулах зорилгоор Засгийн газрын 2023 оны 39 дүгээр тогтоолоор "Гарааны

компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам"-ыг баталжээ. Уг журамд заасны дагуу инновацын төсөл бүртгүүлэх хүсэлт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, оюуны өмчийн эрхийн баталгаажилтын мэдээлэл, тухайн инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа зэрэг холбогдох баримт бичгийг бүрдүүлж, өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага руу <https://project.stf.gov.mn/> цахим системээр хүргүүлнэ. Үүний дараа холбогдох шинжээч баримт бичигт дүгнэлт гаргаж, шаардлага хангасан тохиолдолд Улсын бүртгэлийн ерөнхий газар компанийн нэрийн өмнө "Гарааны" гэсэн тодотголыг оруулж, бүртгэснээр татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлэх боломжтой бөгөөд одоогоор энэхүү тодотголыг авч бүртгүүлсэн 67 гарааны компани байна.

Дээрх татварын хөнгөлөлт, дэмжлэг нь гарааны бизнесийг дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн хэдий ч бүх гарааны бизнесийг төрийн байгууллагад бүртгүүлж, бүтээгдэхүүнийг нь инновацтай эсэхийг төрөөс шийдвэрлэдэг байхаар заасан. Энэ нь аливаа ач холбогдолгүй, зөвхөн хүнд суртлыг үүсгэж байна.

Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар 5 бүлэг, 15 зүйл бүхий Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцүүлэн батлуулсан. Уг хууль нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхэлж байгаа хүн, хуулийн этгээдийг дэмжих, санхүүжүүлэх эх үүсвэрийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийн эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх цахим эдийн засгийг дэмжихэд чиглэгдсэн.

Уг хуулийн хүрээнд Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулж, уг бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологи болон дэвшилтэт технологийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдээс гадна технологийн гарааны бизнес эрхлэгчдэд төрөөс үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийн талаар тусгасан. Түүнчлэн уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д заасан "хиймэл оюун ухаан, их өгөгдөл, блокчэйн,

сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндроксыг байгуулах зохицуулалтыг тусгасан байна.

Хэдий тийм ч, хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрөөс үзүүлэх татварын бус дэмжлэг болоод санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй, санхүүжилтийн төсөв байхгүй байгаа нь хууль тогтоомж хоорондын уялдаа холбоогүй байгааг харуулж байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хуулийн тухай

Монгол Улсын Их Хурлаар 2019 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр батлагдсан Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих хуулийн шинэчилсэн найруулга нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга байрлан үйл ажиллагаа эрхэлдэг улсын бүртгэлд бүртгүүлсэн ашиг олох зорилго бүхий дотоодын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжид үйлчлэх бөгөөд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдгээрийн эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэхэд оршино.

Уг хуулийн нэр томъёоны тодорхойлолтод зааснаар "жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг хэлэх бөгөөд дараах 3 ангилалд хуваагдана:

- "бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 10 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг;
- "жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 10-50 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 300.0 сая-1.0 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг;
- "дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж 50-200 хүртэл ажилтантай, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг, жилийн 1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг.

Хуулийн үйлчлэх хүрээнд хамрахгүй салбарыг хуулийн 7 дугаар зүйлд тогтоож, Жижиг дунд, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуулиар төрөөс баримтлах бодлогын чиглэлийг тогтоож, кластераар хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл,

үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан зэрэг бусад дэмжлэгийн төрлүүдийг дурдсан байна.

Хөрөнгө оруулалтын тухай хууль

Хөрөнгө оруулалтын тухай хууль, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр хэд хэдэн хууль, эрх зүйн баталгаа, түүнчлэн хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах чиглэлээр төрөөс үзүүлэх дэмжлэгийн тодорхой хэлбэрийг бий болгосон. Үүнд, тухайлбал, хөрөнгө оруулагчдын хөрөнгийг нийтийн ашиг сонирхлын үүднээс авахаас бусад тохиолдолд хураан авахыг хориглох, хөрөнгө оруулагчдын оюуны өмчийг хууль ёсны дагуу хамгаалах, хөрөнгө оруулалтын ашгийг эх оронд нь буцаах эрх зүйн баталгаа, талууд харилцан тохиролцсон бол төрийн эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээ хэлэлцээрээс үүссэн маргааныг шийдвэрлэх гадаад, дотоодын арбитрын механизмд хандах зэрэг орно.

Дээрхээс гадна хөрөнгө оруулагчдад нэгээс дээш салбарт хөрөнгө оруулах, төрийн үйлчилгээг тэгш хүртэх, Монгол Улсад бүртгэлтэй санхүүгийн байгууллагын банкаар дамжуулан гадаад валют худалдан авах, хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бараа, үйлчилгээг импортлох, үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээг экспортлох, эсхүл хуульд заасан өөрт олгогдсон үүргийн дагуу өөрт олгогдсон үүрэг зэрэг орно.

Оюуны өмчийн тухай хууль

2020 онд батлагдсан Оюуны өмчийн тухай хуульд “Оюуны өмч” гэж оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон зохиогчийн эрхийн бүтээл, түүнд хамаарах эрхийн объект, үйлдвэрлэлийн өмчийн эрхийг; гэж тодорхойлсон боловч үүнийг хэрхэн хамгаалж байгаа талаар дурдаагүй. Аж үйлдвэрийн өмчийн эрхийн хувьд зөвхөн шинэ бүтээл, ашигтай загвар, дизайн, барааны тэмдэг, газарзүйн заалт байдаг хэдий ч, гарааны компанитай холбоотой дижитал бүтээгдэхүүний ангилал ороогүй байна.

Оюуны өмчийн газраас шинээр бүртгүүлэх зохиогчийн эрхийн мэдүүлгийн маягтад зохиогчийн эрхийн төрөлд компьютерын программ, мэдээллийн сан бүртгэх байдлаар жагсаасан байдаг. Харин дижитал бүтээгдэхүүнийг нарийвчлан бүртгэдэггүй байна.

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүд

Монголын Улсын урт хугацааны “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогын баримт бичигт 9 зорилгыг дэвшүүлсэн бөгөөд эдгээрийн “Амьдралын чанар ба дундаж давхарга” зорилгын хүрээнд Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнесийн чадварыг дээшлүүлэх зорилтыг тусгажээ. Уг зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлэн Дэлхийн банкнаас гаргадаг Энтрепренершип үзүүлэлтийг⁷ 2050 онд 82.5-д хүргэхээр тавьсан байна. Үүнд:

3.3.13.“Залуу энтрепренершип” үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ;

3.3.14.Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ;

3.3.15.Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ;

4.3.4.Гарааны бизнесийг санхүүжүүлэх гарааны хөрөнгийн сан болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгон хөгжүүлнэ;

7.4.26.Салбарын инновацын үйл ажиллагааг дэмжих, гарааны бизнест хөрөнгө оруулалт хийхэд чиглэсэн тусгай хөрөнгө оруулалтын сан байгуулж, ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Эндээс харахад Хөрөнгө оруулалтын тухай хууль нь хөрөнгө оруулагчдад үзүүлэх татварын хөнгөлөлтийн зохицуулалт нь хөгжингүй орнуудтай харьцуулахад хангалтгүй, Инновацын тухай хуульд гарааны бизнест татварын хөнгөлөлт үзүүлэхээр тусгасан ч гарааны бизнесийн тодорхойлолт нь явцуу, хамрах хүрээ хязгаарлагдмал зэргийг сайжруулах шаардлагатай. Харин Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хүрээнд МТҮП нь ажлын албаны үүрэгтэйгээр мэдээллийн технологийн гарааны бизнесийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, үйлдвэрлэх, хөгжүүлэх, нэвтрүүлэхтэй холбоотой татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэхээр тусгасан ч уг хуулийн

⁷ World Bank https://wbi.worldbank.org/en/data/exploretopics/wbi_rbWorld Bank's annual index of women's entrepreneurship and business management

зохицуулалт хэт ерөнхий байгаагаас үүдэн хуулийг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй, гарааны бизнесийн хөгжилд шаардлагатай хүчин зүйлийг цогцоор нь агуулаагүй байна.

4.4 Гарааны бизнесийн санхүүжилт, хөрөнгө оруулалт

Гарааны бизнес эхлэх эсхүл өргөжүүлэхэд хөрөнгө оруулалтыг олох нь олон бизнес эрхлэгчдэд тулгардаг хамгийн том саад бэрхшээлүүдийн нэг юм (Berger, Cowan, Frame, 2011). Гарааны бизнесийн амжилт хөгжлийн асуудлууд нь санхүүжилтийн боломжоос ихээхэн хамаардаг бөгөөд бизнес эхлэх хамгийн чухал үе шатуудын нэг нь санхүүгийн хангалттай эх үүсвэрийг бий болгох явдал юм. Гарааны бизнес хөгжлийн аль үе шатанд байгаагаас хамаарч боломжтой санхүүжилтийн олон хэлбэрийн аль нь яг тохирох вэ гэдэг нь хөрөнгө оруулалтын өгөөж, зээлийн нөхцөл, санхүүгийн мөнгөн хөрөнгөөс гадна төрөөс үзүүлэх дэмжлэг байгаа эсэх зэрэг олон зүйлийг харгалзан үзэх болдог. Гарааны компанийн хөгжлийн үе шатыг дараах байдлаар ангилдаг:

- **Эхлэлийн үе шат** (Seed stage)- Бизнесийн шинэ санааг хөгжүүлэх, зах зээлийн судалгаа хийх, техник–эдийн засгийн үндэслэл боловсруулах, бүтээгдэхүүний загвар, үйлчилгээний концепц гаргах, бизнес төлөвлөгөө бэлтгэх, хөрөнгө санхүүжилтийн эх үүсвэр олох гэх зэрэг үйл ажиллагаа явагддаг.


- **Эхэн үе шат** (Early stage)- Бизнесийн шинэ санааг туршин хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд эхлэн гаргаж бизнесийн үйл ажиллагааг эхлэн явуулах үе шат.

- **Дунд шат** (Midstage)- Бизнес тогтвортой болж, компанийн үйл ажиллагаа жигдрэн, бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэж, зах зээлд эзлэх байр суурь бэхэжнэ.

- **Сүүлийн шат** (Last stage)- Компанийн үйл ажиллагаа бүрэн тогтворжиж, гарааны компаниын шатнаас гарна. Цаашид хөрөнгийн зах зээлд нээлттэй хувьцаа гаргах боломжтой.

Түүнчлэн гарааны бизнесийн хөгжлийн үе шатаас хамааран хөрөнгө татах арга хэлбэрийг дараах байдлаар ангилдаг (Leach & Melicher, 2012).

Зураг 4. Гарааны бизнесийн хөгжлийн үе шат, хөрөнгө оруулалтын хамаарал⁸



Эхлэлийн үе шатанд байгаа аливаа компанийн хувьд бизнес эрхлэгч санаагаа бизнес болгон хувиргахад санхүүгийн эх үүсвэр дутагдаж байгаа үед үрийн санхүүжилт (Seed financing) шаардлагатай болдог. Энэхүү санхүүжилтийг бизнесээ өргөжүүлэх анхны хөрөнгө оруулалт гэж нэрлэдэг. Мөн Дэлхийн гарааны компанийн экосистемийн тайлан (ДСЭТ)-д уг хөрөнгө оруулалтыг А ангиллын санхүүжилт гэх бөгөөд энэ төрлийн санхүүжилтийн дэлхийн дундаж нь 15 сая ам.доллар, медиан нь 10 сая ам.доллар байгааг дурджээ.

Гарааны бизнесийн санхүүжүүлэх түгээмэл арга

Олон улсад гарааны бизнесийг санхүүжүүлэх олон төрлийн арга байдгаас түгээмэл хэрэглэгддэг аргуудыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 7. Гарааны бизнесийн санхүүжүүлэх түгээмэл арга⁹

№	Санхүүжилт ийн төрөл	Агуулга	Тохиромжтой үе шат	Давуу тал	Сул тал
1	Өөрийн санхүүжилт (self- financing)	Бизнес эрхлэгч гарааны бүр эхэн үед өөрийн хөрөнгөөр санхүүжилт хийх төрөл бөгөөд энэ нь	Бизнесийн хэмжээ, цаашид өргөжих байдал, шаардлагатай хөрөнгө санхүүжилтийн хэрэгцээ	Бизнес болон компаниа бүрэн хяналтдаа байлгаж чаддаг.	Бизнес эрхлэгчдийн хүрээлэлд орох, танилын

⁸ Гарааны бизнесийн санхүүжилтийн хүртээмж, З.Алтанчимэг, Ж.Сарантуяа, Ц.Болортуяа

⁹ Гарааны бизнесийн санхүүжилтийн өнөөгийн байдал судалгаа

		компания босгох, хөгжүүлж эхлэхэд хангалттай хөрөнгө оруулалт болно.	зэргээс шалтгаалан гарааны бизнесийн эхэн үед тохиромжтой.		хүрээ өргөжүүлэхэд хүндрэлтэй. Хувийн харилцааны оролцоо их тул хөрөнгө оруулагчийн нөлөө их болох, хоорондын харилцаа муудах, бизнесийг унагах магадлалтай.
2	Гэр бүл, найз нөхөд	Ихэнхдээ бизнес эрхлэгчид дэмжлэг үзүүлж сонирхолтой, биелэх боломжтой бизнес төсөлд хөрөнгө оруулдаг.	Санхүүжилтийн хэмжээ хязгаарлагдмал, зөвхөн бизнес ба компания байгуулах эхэн үед л хангалттай байх магадлалтай.	Хялбар, албан бус үйл явцтай, хөрөнгө оруулагчтай шууд харилцах, эрсдэлийн үнэлгээ, шалгуур бараг байхгүй.	
3	Нийтийн санхүүжилт (Crowd-Funding)	Хэрэглэгч нь өөрсдөө хөрөнгө оруулагч болдог бөгөөд хэд хэдэн хүмүүс эсхүл олон нийт нийлж шинэ төсөлд бага хэмжээний хөрөнгө оруулалтыг тус бүр хийснээр нийт хөрөнгийн хэмжээг бүрдүүлж чаддаг. Үүнд төсөл санаачлагч, ашиг авах сонирхолтой олон нийт, бизнес эрхлэгч, санхүүжилтийн механизмын дагуу холбогч талууд оролцогч байна.	Төслийн санааг танилцуулж буй эхэн үед тохиромжтой.	Төслийн санаа хэр зэрэг итгэлтэй вэ гэдгээсээ илүүтэй хэн нэгний оруулж буй хөрөнгө, түүнээс авах ашгийн хэмжээг тэнцвэртэй байлгах нь хамгийн чухал.	
4	Өөрийн нөөц бололцоог ашиглах (Bootstrapping)	Банкнаас мөнгө зээлж хөрөнгө босгохгүйгээр бүтээлчээр нөөцөө бүрэн ашиглана. Энэ нь дотооддоо олсон орлого, зээлийн карт, орон сууцны зээл, хэрэглэгчдээс авсан урьдчилгааны хөлс зэргээс ихээхэн хамааралтай.		Өөрийн нөөц бололцоог ашиглан цагт баригдахгүй таатай нөхцөлөөр санхүүжилт хайх, аажим ашиг бололцоотой.	Бусад санхүүжилттэй компанитай харьцуулахад хүссэнээрээ компания өргөжүүлэх бололцоогүй, борлуулалт, зах зээл ба өрсөлдөөнд эзлэх байр суурь хязгаарлагдмал
5	Ухаалаг лизинг (Smart Lease)	Бизнес эрхлэгч үл хөдлөх хөрөнгийг лизинг хийж тодорхой хэмжээний мөнгийг гараагаа эхлэхэд олж авах боломжтой.	Гарааны бизнес санхүүжүүлэлтийн хэмжээг бууруулахад эхэн үедээ лизинг авах нь тохиромжтой.	Үнэтэй тоног төхөөрөмжийг авахад лизинг хийх нь ашигтай бөгөөд банкны зээлтэй харьцуулахад арай зардалтай боловч ашиглаж эхлэхэд зардал буурна.	
6	Анжел – албан бус хөрөнгийн зах зээл (Business Angels –	Анжел нь амжилтад хүрнэ гэдэгт итгэсэн гарааны бизнес, төсөлд хөрөнгө оруулж, хариуд нь өмч эзэмших болзол тавьдаг өндөр орлоготой	Анжел ихэвчлэн технологийн инновац эсхүл сайн мэддэг салбартаа хөрөнгө оруулалт хийдэг ба багадаа 5-7 жилд өгөөж	Анжел нь албан венчур зах зээлтэй харьцуулахад албан бус шинжтэй,	Анжел нь ижил төстэй бүлэг хөрөнгө оруулагчид байх ч гарааны

	Informal Risk Capital Market)	санхүүжүүлэгчид байдаг. Мөн зөвхөн ашгийн төлөө бус зорилгоор ч хөрөнгө оруулдаг бөгөөд албан бус хөрөнгийн зах зээлд нэмэлт дэмжлэг үзүүлж байгаа гэдэг утгаараа венчур зах зээлтэй нэлээд төстэй.	өгөх урт хугацаандаа ашиг хүртэнэ гэсэн хүлээлттэй.	тавигддаг шаардлага, нөхцөл, заалт нь нарийн бус.	бизнесийг хөгжүүлэхэд хэрхэн оролцоотой байх, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчийн үзэл бодлыг нэгтгэх зэргээс үүдэн бүлэг дотроо ялгаатай байдаг нь гарааны бизнес амжилттай байх эсэхэд нөлөөлдөг.
7	Венчур хөрөнгө оруулалт-эрсдэлт хөрөнгийн зах зээл (Venture Capital – Risk Capital Market)	Энэ нь нэг төрлийн санхүүгийн зуучлалын арга бөгөөд ашиг олохын тулд компанид өөрсдийн ашиг сонирхол, хувь хүртэх байдлаар холбох зорилготой. Тодорхойгүй, эрсдэл ихтэй шинэхэн гарааны бизнест хөрөнгө оруулж, хариуд нь зах зээлд байгаагаас өндөр ашиг хүртэхийг эрмэлздэг. Улс орнуудын туршлагаас үзэхэд АНУ-д венчур хөрөнгө оруулалт нь эрүүл мэнд, мэдээллийн технологийн салбарт ихэвчлэн хөрөнгө оруулалт хийгддэг.	Гарааны эхэн үеэс эхлээд нээлттэй хувьцаат компанийн аль алинд нь тохиромжтой хөрөнгө оруулалтын хэлбэр.	Мөнгөн болон оюуны хөрөнгө оруулалтын аль алиныг оруулдаг. Тэд бизнесээ гардан удирдаж буй удирдлагад зөвлөх, томоохон мэргэжлийн хүрээнд нэгдэх, компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилладаг.	
8	Бизнес альянс (Business Alliances)	Компани бусад аж ахуйн нэгж компаниудтай ашиг олох, зардлаа бууруулах зорилгоор хамтрах хэлцэл байгуулна.	Бизнес альянсыг цаг хожиж, бүтээгдэхүүнээ зах зээлд түргэн гаргах, борлуулалтын сувгийг бүрэн ашиглах, газар зүйн хувьд тэлэх, хэрэглэгчдэд хүрэх, бүтээгдэхүүний найдвартай байдлыг таниулах, дангаараа ажиллахад нөөц хүрэлцэхгүй байх, хэрэглэгчийн таашаалд нийцүүлэх, бүтээгдэхүүн хөгжүүлэх, хамрах хүрээгээ нэмэгдүүлж ашгаа нэмэх, өрсөлдөөнд хамтрах, бизнесийн туршлага хуримтлуулах, төсөлд хамтрах зорилгоор байгуулдаг.	Компани дангаараа ажиллахад нөөц дутмаг байх үед энэ арга тустай ч, цаашид компани амжилттай ажиллаж эхлэхэд заавал нэгдэх шаардлага багасдаг.	
9	Компанийн хөрөнгө оруулагчид (Corporate Investors)	Компанийн хөрөнгө оруулагчид жижиг компанийг худалдан авах замаар өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг	Олонх бизнес эрхлэгчид өнөө үед компани байгуулахдаа л томоохон санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг		Компанийн хөрөнгө оруулалт нь жижиг бизнесүүд

		нэмэгдүүлж, жижиг бизнесүүд үйл ажиллагааны чиглэлээ цаашид өргөжүүлэхэд хөрөнгө оруулалтыг ашигладаг.	компани тэднийг худалдан аваасай гэсэн зорилготойгоор байгуулж, нэгэнт томоохон компанийн нэг хэсэг болсны дараа бусад асуудлаа шийддэг болсон.	өрсөлдөгчидтэй түншлэх байдал болон шууд хөрөнгө оруулагч компанитай өрсөлдөх боломжийг хаадаг. Эдгээр нь эрсдэл өндөр бизнесийг санхүүжүүлэх нь түгээмэл, арилжааны банктай харьцуулахад харьцангуй өндөр хүүтэй зээл олгодог.
10	Санхүүгийн компаниуд (Finance Companies)	Арилжааны банкнаас шинэ компани зээл авч чадахгүй тохиолдолд өрөөр санхүүжүүлэх боломжит аргын нэгэн нь санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг компаниуд.		
11	Банкууд (Banking Institutions)	Гараанаас эхлээд цааш үйл ажиллагаа явуулах богино хугацааны капиталыг банкнаас зээлж хөрөнгө мөнгө олж авах нэн тохиромжтой арга.	Банкны зээл авахад үл хөдлөх хөрөнгө, батлан даалт байршуулахыг шаарддаг. Хэдийгээр банк компанийн санхүүжилтэд чухал эх сурвалж ч харин мэдлэгт суурилсан гарааны бизнесүүд үл хөдлөх хөрөнгөгүй, банк ч эдгээр төрлийн гарааны бизнест хөрөнгө оруулдаггүй байна.	Зээл, зээлийн хүүгээ төлөх чадвартай байх хэрэгцээ үүсдэг нь компанийг санхүүгийн хувьд эрх чөлөөгүй болгодог.
12	Засгийн газрын санхүүжилт (Government Financing)	Дэлхийн улс орнууд гарааны бизнесийн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Засгийн газрууд 1-т шинэ гарааны компаниуд тодорхой тооны ажлын байрыг нэмэгдүүлдэг, 2-т нийгэм, эдийн засагт таатай өөрчлөлт авчирдаг гэдэг үндэслэлээр буюу нийгэм, эдийн засгийн шалтгаанаар санхүүжүүлэх сонирхолтой.	Гарааны компаниуд санхүүжилт олж авч чаддаггүй учраас Засгийн газрын хөрөнгө оруулалтын асуудлыг дэмжигчид гарааны бизнесийг бүр эхэн үеэс нь хөрөнгө оруулах зүйтэй хэмээн үздэг.	
13	Факторинг (Factoring)	Ихэнх тохиолдолд компанийн мөнгө авлага болон гацдаг бөгөөд энэ мөнгө нь ирээдүйд орж ирэх авлага болон үлддэг. Хэдий ирээдүйд авах авлагатай ч компанид шууд хэрэглэх мөнгөн хөрөнгийн хэрэгцээ зайлшгүй гарна. Бэлэн мөнгөний хомсдолыг факторинг ашиглах байдлаар багасгаж болдог. Жижиг бизнесүүд өөрсдийн бизнесийг санхүүжүүлэхэд зээлийн картыг ашиглана.		Бизнес эрхлэгч богино хугацаанд мөнгөтэй болж, худалдан авсан тал ирээдүйд орж ирэх авлагаар боломжийн ашиг хийх боломж ч үүсдэг.
14	Кредит карт (Credit cards)	Хэрэглэгч зээлээ хамгийн бага хэмжээгээр сардаа төлөлт хийж үлдсэн хэсгийг		Зээлийн картын цаг хугацаандаа эргэн төлөлт хийгдэх нь л чухал болохоос
				Боломжийн сонголт хэдий ч бизнесийг ийм байдлаар санхүүжүүлэх нь эрсдэлтэй

	тодорхой хүүтэй хамт төлөх боломж олгодог.	мөнгөө юунд, хэрхэн зарцуулж байгаад ач холбогдол өгдөггүй.	тул болгоомжлох нь зүйтэй.
15	Хувьцаа арилжих (Public Stock Sales) Компани хувьцаагаа олон нийтэд арилжиж хөрөнгө босгодог. Хувьцааг энгийн буюу хөрөнгийн зах зээлд хэн ч худалдан авч болох байдлаар эсхүл хязгаарлагдмал хаалттай байдлаар тодорхой хувь хүмүүст арилждаг.	Энгийн хувьцаа гаргах нь их хэмжээний хөрөнгө босгох боломжтой.	Өмчийн эзэн өмчөөсөө саланги болох, хяналтаа алдах сул талтай.

Бизнес эрхлэгч үйлдвэрлэлээ бүрэн хэмжээгээр явуулж бүтээгдэхүүнээ зах зээлд гаргах хүртэлх бүрэн хэмжээний хөрөнгө оруулалт татах хэрэгтэй болдог ба бизнесийн эхэн үед эхлэлийн санхүүжилт (Startup financing) хийдэг. Энэ үед бизнесийн тэтгэгч сахиусан тэнгэрүүд, венчур хөрөнгө оруулагчаас санхүүжилт босгох нь илүү тохиромжтой байдаг. Энэ нь инновац бүхий бизнесийн хувьд ашигтай урт хугацаанд хөгжих боломж олгодогтой холбоотой. Хэдийгээр энэ үед хөрөнгө оруулалтын хэмжээ төдийлөн их байдаггүй ч судалгаа, хөгжүүлэлт, аливаа шинэ санааг дэмжиж хөгжүүлэх, түүнийг бизнес болтол хөгжүүлж үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай дараагийн хөрөнгө оруулалт авах тэр үе шатанд хүргэхэд ихээхэн тустай болдог байна¹⁰.

Харин венчур капитал нь эдийн засагт өрсөлдөөнийг хүчтэй болгож шинэлэг бизнесийг дэмжиж хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулдаг¹¹ бөгөөд зарим венчур хөрөнгө оруулагчид уламжлалт байдлаас өөрөөр буюу дөнгөж эхлэлийн үед нь хөрөнгө оруулалт хийж эхэлдэг.

Үүнээс гадна банкнаас зээл авч санхүүжүүлэх нь гарааны бизнес эхэн үедээ зээл авах боломжгүй байдаг бөгөөд энэ нь үл хөдлөх хөрөнгө, барьцаа хөрөнгөгүй байдагтай холбоотой байдаг тул хөрөнгө оруулагч сахиусан тэнгэрүүд, венчур хөрөнгө оруулагч нар энэ үеийн тохиромжтой санхүүжилт болдог.

¹⁰ Гарааны бизнесийн санхүүжилтийн хүртээмж, З.Алтанчимэг, Ж.Сарантуяа, Ц.Болортуяа

¹¹ Hellmann Thomas and Puri Manju, 2003

ЖАЙКА-аас 2024 онд хийсэн “Монголын гарааны бизнесийн экосистем” судалгаанд Монгол Улсын гарааны бизнесийн экосистемийн нийт үнэлгээ 424 тэрбум төгрөг байгаагаас 96 тэрбум төгрөгийн хөрөнгийг гарааны бизнес эрхлэгчид босгосон байна.

Тухайлбал, судалгаанд оролцсон компаниудын анхны санхүүжилтийн нийт дүн 13.4 тэрбум төгрөг буюу 73.8 хувь нь хувийн хадгаламж, 25 хувь нь найз нөхөд, гэр бүлийн дэмжлэг, үлдсэн 17.5 хувь нь бусад бизнесийн орлогоос босгосон байна.

Зураг 5. Анхны санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл



Явцын санхүүжилтийн хувьд гарааны бизнес эрхлэгчид хувийн хадгаламж (39 хувь), бусад бизнесийн орлого болон гэр бүл, найз нөхдөөсөө явцын санхүүжилтээр хөрөнгө оруулалт хийж байгаа нь харагдаж байна. Харин гадаадын хөрөнгө оруулалт (14.6 хувь)-аас илүү дотоодын хөрөнгө оруулалт (56.1 хувь) илүү буюу бараг 4 дахин өндөр байна. Түүнчлэн гарааны бизнесийн компаниуд барьцаалах хөрөнгө хангалтгүй байдаг гэсэн хэдий ч 12.2 хувь нь банкны зээлээр явцын санхүүжилтийг босгосон харагдаж байна.

Зураг 6. Явцын санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл

Түүнчлэн дээр дурдсан төрлүүдээс гадна гарааны бизнесийн экосистемийг бий болгохтой холбоотой олон улсын донор байгууллагууд дэмжлэгийн үзүүлдэг бөгөөд Монгол Улсын хувьд дараах агуулгын хүрээнд дэмждэг байна. Тухайлбал,

Хүснэгт 8. Гарааны бизнесийн экосистемийг бий болгохтой холбоотой хөгжлийн түншүүдийн дэмжлэгийн агуулга

№	Хөгжлийн түнш	Дэмжлэгийн агуулга
1	ЖАЙКА	• МОНЖА хурдасгуур хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. • Экосистемийн судалгаа хийсэн.
2	Европын сэргээн босголтын банк (EBRD)	• Star venture хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
3	Азийн хөгжлийн банк (ADB)	• ADB Ventures нь KITE-тэй түншлэл байгуулсан
4	Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (UNDP)	• "Activated 2030" санаачилгын хүрээнд Монголын гарааны бизнес эрхлэгчдийн суурь судалгаа хийсэн
5	Дэлхийн банк (WB)	• "2020-2025 онд Монголын хамгийн эмзэг бүлгийн хөдөө орон нутгийн залууст зориулсан нийгэм-сэтгэл зүйн ур чадвар бүхий бизнес эрхлэлтийг дэмжих төсөл": Монголын хамгийн ядуу 25 орон нутгийн 6,000 гаруй залууст нийгэм-сэтгэл зүйн болон гарааны бизнес эрхлэх боловсрол олгож байна.

Шинжлэх ухаан, технологийн сан: Монгол Улсын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын түвшинг дэлхийн жишигт хүргэх, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор 1993 онд уг сан байгуулж, өнөөг хүртэл үйл ажиллагаа явуулж байна. Уг сангаас нийт 941 төслийг 22,6 тэрбум төгрөгөөр буюу 1 төсөлд дунджаар 22 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. Хэдий тийм ч уг сангийн зарцуулалт сүүлийн 2-3 жилд зориулалтын дагуу ашиглагддаггүй гэсэн дүгнэлтийг аудитын газраас удаа бүр гаргасан байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан: Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан 2009 онд байгуулагдсан бөгөөд улсын төсөв, Засгийн газрын бонд, Хөгжлийн банкны дамжуулан зээл болон орон нутгийн төсвөөс нийт 737,6 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 8946 төсөлд 1,1 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгожээ. Эдгээр зээлдэгчид нийтдээ 39,827 ажлын байрыг хадгалж, 54,622 ажлын байр шинээр бий болгосон байна. Зээлдэгчдийн 7398 буюу 82.8 хувь нь 854.1 тэрбум төгрөгийн буюу нийт зээлийн 78.8 хувийг бүрэн төлж барагдуулсан бөгөөд 2024 оны эцсийн байдлаар 1,533 зээлдэгчийн 228,9 тэрбум төгрөгийн үндсэн зээлийн авлагатай.

2009-2024 оны хооронд 33,458 төсөлд 5,0 их наяд төгрөгийн хүсэлт ирснээс зээл хүсэгчийн 26,7 хувь, санхүүжилтийн 22 хувийг шийдвэрлэсэн. Үүнээс энэ хугацаанд 6,694 хүнсний болон хөнгөн үйлдвэрийг өргөтгөж, 2,252 үйлдвэр шинээр бүтээн байгуулжээ. Сүүлийн таван жилд 960 төсөлд 116.5 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилт олгосноор 5189 ажлын байр шинээр бий болгож, 3552 ажлын байрыг хадгалж үлдсэн талаар тус сангаас мэдээлсэн байна¹².

*Хүснэгт 9. Жижиг, дунд үйлдвэрийн сангаас олгосон төслийн мөнгөн дүн эдийн засгийн салбараар (зуун сая төгрөг)*¹³

	2020	2022	2023	2024	2025
Олгосон төслийн дүн	22,816.4	19,181.8	35,436.4	38,348.5	13,630.5
Үүнээс: Бусад	-	-	-	692.5	170.0
Эзлэх хувь	-	-	-	1.8	1.25

Дээрх тоон мэдээлэл, бусад үзүүлэлтээс харвал Жижиг, дунд үйлдвэрлэлийн хууль тогтоомж, сангууд нь мэдээллийн технологийн гарааны бизнесийг мэдэгдэхүйц дэмжихгүй байгаа бөгөөд олгогдсон зээлүүд дунд энэ чиглэлийн зээлийн эдийн засгийн ангилал байхгүй тул бусад гэсэн ангилалд орсон гэж үзэж байна. Хэдий тийм ч 2024-2025 онд бусад ангилалд олгосон зээлийн эзлэх хувийг тухайн онд олгосон зээлтэй харьцуулахад 0.55 хувь буурсан байна.

*Хүснэгт 10. Эрдэм шинжилгээний судалгааны боловсруулалтын ажлын 2021-2023 оны төсөв, гүйцэтгэл*¹⁴

	2021 оны төсөв		2021 оны гүйцэтгэл		2023 оны төсөв		2023 оны гүйцэтгэл	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Инновацийн төсөл	16	331.2	16	331.2	3	-	-	-
Инновацийн грант төсөл	-	-	-	-	3	125,005.30	-	120,000

2022 онд инновацтай холбоотой нээлттэй мэдээлэлгүй.

¹² <https://www.parliament.mn/nn/73906/>

¹³ Жижиг, дунд үйлдвэрийн газрын цахим хуудас, <https://sme.gov.mn/visualdata>

¹⁴ ШУТСан, Санхүүгийн мэдээлэл

Засгийн газраас үзүүлж буй бусад дэмжлэг: Инновацийн тухай хуулийн дагуу Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор “Инновацийн төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”, “Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ыг тус тус батлуулсан. Ингэснээр шилдэг инновацийн шийдэлд 20 хүртэлх сая төгрөгийн грант олгох, инновацийн төсөлд 60 хүртэлх сая төгрөгийн буцалтгүй санхүүжилтийг олгох боломжтой болсон.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт: Инновацийн тухай хуулийн дагалдан гарсан Засгийн газрын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан “Гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу одоогийн байдлаар нийт 67 гарааны компани бүртгэгдсэн байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд 6 гарааны компани нийт 15,686,739 төгрөгийн ААНОАТ-ын хөнгөлөлт, 2 гарааны компани НӨАТ-ын тухай хуулийн 13.1.19 дэх заалтыг үндэслэн нийт 245,269,799 НӨАТ-ын чөлөөлөлт, 1 гарааны компани нийт 29,463,833 төгрөгийн гаалийн болон НӨАТ-ын чөлөөлөлтөд хамрагдсан байна.

Гарааны бизнес болон инновацтай холбоотой дэмжлэгийн гол байгууллага нь Эдийн засгийн хөгжлийн яам байна. 2022 он хүртэл Боловсрол, шинжлэх ухааны яам (2024 оны 7-р сард нэрээ Боловсролын яам болгон өөрчилсөн) нь тус санаачилгын үндсэн байгууллага байсан ч энэ үеэс эхлэн Эдийн засгийн хөгжлийн яам удирдан чиглүүлэхээр болгож Засгийн газар шийдвэрлэсэн. Харин бодит хэрэг дээр Эдийн засаг хөгжлийн яам, Боловсролын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамд өөр өөрийн яамны харьяалах салбарын хүрээнд оролцож байгаа байдалтай байгаа ба одоогийн байдлаар хоорондын хамтын ажиллагаа гэх тодорхой зүйл харагдахгүй байна.

БҮЛЭГ 5. ГАРААНЫ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Уг судалгаанд нийт 80 байгууллагын төлөөллийг хамруулсан бөгөөд эдгээрээс 35 нь гарааны бизнесийн экосистемийн оролцогч байгууллага, 45 нь гарааны компани бизнес эрхлэгч юм. Эдгээр судалгаанд оролцогчдын хэмжээнд санхүүжилтийн хэмжээ 2023 оноос 2024 онд мэдэгдэхүйц нэмэгдэж, 2.7 тэрбум төгрөгөөс 21.7 тэрбум төгрөг буюу 7.9 дахин өссөн байна. Гэсэн хэдий ч, судалгааны баг энэхүү мөнгөн дүн нь гарааны бизнесийн экосистемд оруулсан санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн бус харин судалгаанд оролцогчдын тоог нэмэгдүүлсэнтэй холбоотой болохыг онцолж байна.

Судалгаанд оролцсон гарааны компаниудын санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд 18.7 тэрбум төгрөг буюу 86.17 хувь нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, 1.2 тэрбум төгрөг буюу 5.6 хувийг олон улсын байгууллагаас, 1 тэрбум төгрөг буюу 4.6 хувийг улсын төсвөөс, 365 сая төгрөг буюу 1.7 хувийг спонсороос, харин 143 сая төгрөг буюу 0.7 хувийг краудфандинг хэлбэрээр төвлөрүүлсэн байна.

Зураг 8. Санхүүжилтийн эх үүсвэр



Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд 2023 оныг 2024 онтой харьцуулахад дараах өөрчлөлтүүд гарсан байна. Тухайлбал,

- Улсын төсвийн эх үүсвэр 20 хувиар багассан. Энэ нь төрийн зүгээс гарааны бизнесийг шууд санхүүжүүлэхээс илүүтэйгээр дэд бүтцийг сайжруулах, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэгт анхаарлаа хандуулж байгааг илтгэж болно.

- ОУБ-ын эх үүсвэр 40 хувиар өссөн. Олон улсын байгууллагууд Монголын гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэхэд сонирхолтой хэвээр байгаа бөгөөд төсөл хөтөлбөрүүдээ идэвхтэй хэрэгжүүлж байна.
- Спонсорын эх үүсвэр 36 хувиар өссөн. Корпорациуд болон бусад байгууллагууд гарааны бизнесийн тэмцээн уралдаан, арга хэмжээг ивээн тэтгэх замаар дэмжлэг үзүүлсээр байна.
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэр 7.9 дахин нэмэгдсэн. Энэ нь хөрөнгө оруулалтын компаниуд судалгаанд илүү идэвхтэй хамрагдсан эсвэл бодит хөрөнгө оруулалт нэмэгдсэн аль алинтай нь холбоотой байж болно.

Түүнчлэн, экосистемийн санхүүжилтийн эх үүсвэрт 2024 онд краудфандинг чиглэлийн "Fundea.mn" гэх хамтын санхүүжилтийн шинэ платформ нэвтэрсэн нь онцлох үйл явдал юм. Энэхүү платформ нь нийт 25 гарааны компани компанид санхүүжилт татан төвлөрүүлэхэд тусалсан байна. Хамтын санхүүжилт нь жижиг хөрөнгө оруулагчдад гарааны компаниудад хөрөнгө оруулах боломжийг олгодог бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх чухал алхам болжээ.


Судалгаанд оролцсон гарааны компаниудын санхүүжилтийн төрлийн хувьд ойролцоогоор 18.7 тэрбум төгрөг буюу 86.17 хувь нь хөрөнгө оруулалт хэлбэрээр, 2.3 тэрбум төгрөг буюу 10.6 хувь нь буцалтгүй тусламж, 560.0 сая төгрөг буюу 2.58 хувь нь зээл, харин үлдсэн 0.66 хувь буюу 143.0 сая төгрөг нь хамтын санхүүжилт хэлбэртэй байна.

Зураг 9. Санхүүжилтийн хэлбэр



Судалгаанд хамрагдсан санхүүжилт олгосон байгууллагын хувьд хөрөнгө оруулалт хэлбэрээр 27 хувь, буцалтгүй тусламж хэлбэрээр судалгаанд оролцогчдын 91 хувь, зээл хэлбэрээр санхүүжүүлсэн 560.0 сая төгрөгийг судалгаанд оролцогчдын 14 хувь нь тус тус олгосон. Зарим байгууллага нь хэд хэдэн санхүүжилт олгосон байгаа тул эдгээр тоо нь давхардсан байдлаар орсон болно.

Зураг 10. Санхүүжилт олгож буй байгууллагын эзлэх хувь болон хөрөнгө оруулалтын хэлбэр



Судалгаанд хамрагдсан гарааны бизнесийн экосистемд оролцогчдын 45 хувь нь бэлэн мөнгөөр, 36 хувь нь бэлэн мөнгө болон ажил, үйлчилгээ хосолсон байдлаар, харин 18 хувь нь бэлэн бус ажил, үйлчилгээ хэлбэртэйгээр гарааны компаниудад санхүүжилт олгосон байна.

Зураг 11. Санхүүжилт олгосон хэлбэр



2024 онд давхардсан тоогоор нийт 264 гарааны компани санхүүжилт нийт 21.6 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 71 хувиар өссөн үзүүлэлттэй

байна. Өөрөөр хэлбэл, нэг гарааны компани компани хамгийн ихдээ 2 тэрбум, хамгийн багадаа 1.5 сая төгрөг, дунджаар 82.1 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Хүснэгт 11. Гарааны компанийн санхүүжилт авсан үнийн дүн

Эх үүсвэр	Гарааны компанийн тоо	Хамгийн их (₮)	Хамгийн бага (₮)
Улсын төсөв	80	20,000,000	10,000,000
Олон Улсын байгууллага	72	70,000,000	5,000,000
Хөрөнгө оруулалт	54	2,000,000,000	20,000,000
Спонсор	20	125,000,000	1,500,000
Хамтын санхүүжилт	25	53,000,000	3,200,000

Судалгаанд хамрагдсан гарааны компанийн 2024 онд авсан санхүүжилтийн хувьд 57.2 хувь нь буцалтгүй тусламж болон грант, 17.42 хувь нь зээл, 15.91 хувь нь хөрөнгө оруулалт хэлбэрээр авсан бол 9.47 хувь нь хамтын санхүүжилтийн төрлөөр авсан байна.

Зураг 12. Гарааны компаниудын авсан санхүүжилтийн төрөл



Судалгаанд хамрагдсан гарааны компанийн 2024 онд авсан санхүүжилтийн 70.9 хувь нь дотоодын санхүүжилт авснаас 29.7 хувь дотоодын хөрөнгө оруулагч/сан, 15 хувь нь Засгийн газрын дэмжлэг болон грант, 12 хувь нь дотоодын хурдасгуур хөтөлбөрөөс авч, 14.2 хувь зээлээр санхүүжсэн байна. Харин нийт 6.8 хувь нь гадаадын хөрөнгө оруулалт буюу сан, олон улсын улсын тэмцээнээс санхүүжигдсэн байгаа боловч

ихэнх нь буюу 22.3 хувь нь ямар нэгэн төрлийн санхүүжилт аваагүй гэж хариулсан байна.


Зураг 13. Гарааны компаниудын авсан санхүүжилтийн эх үүсвэр



Эндээс харахад дотоодын хөрөнгө оруулагчид гарааны бизнесүүдэд санхүүжилт олгоход хамгийн чухал үүрэг гүйцэтгэж байна. Төрийн болон дотоодын тэмцээн, хөтөлбөрүүд мөн тодорхой хэмжээгээр дэмжлэг үзүүлж байгаа ч, гадаадын хөрөнгө оруулалтын хүртээмж харьцангуй бага хэвээр байгаа нь гарааны компаниуд олон улсын зах зээлд гарах, гадаад хөрөнгө оруулалт татахад хүндрэлтэй байгааг харуулна. Судалгаанд хамрагдсан 45 гарааны бизнесийн 22.3% нь 2024 онд огт санхүүжилт аваагүй байгаа нь гарааны бизнесийн санхүүжилтийн хүртээмж хангалтгүй хэвээр байгааг, ялангуяа эхний шатанд олон гарааны компани санхүүгийн хүндрэлтэй тулгарч байгааг илтгэнэ.

Судалгаанд хамрагдсан гарааны бизнесийн 77.7 хувь нь ямар нэгэн хөрөнгө оруулалт авч байсан бөгөөд тэдний хөрөнгө оруулалтын үе шатыг нь зураг 15-д үзүүлэв. Хөрөнгө оруулалт авсан компаниудын дийлэнх нь Angel болон Pre-seed шатанд байгаа нь Монголын гарааны бизнесийн экосистем харьцангуй эхний шатандаа хөгжиж байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, цөөн тооны гарааны компаниуд л өндөр өсөлттэй, олон сая долларын үнэлгээтэй болоод Series шатны хөрөнгө оруулалт татсан байна. Мөн Angel-аас Series хүртэл үе шат бүрд хөрөнгө оруулалт авсан бизнесийн тоо 1 байгаа бол Angel дээр 2 удаа хөрөнгө оруулалт татсан 4 бизнес байна. Энэ нь гарааны компаниуд үе шат ахих тусам хөрөнгө оруулалт татах нь хүндрэлтэй болж, цөөрч байгааг харуулж байна.


Зураг 14. Гарааны компаниудын хөрөнгө оруулалт татсан үе шатууд



Дэлхийн банкны 2023 оны тайланд Монголын экосистем эхний шатандаа байгаа бөгөөд "unicorn" компани байхгүй, цөөн тооны гарааны компани санхүүжилт татсан гэж дурдсан нь энэхүү дүгнэлтийг бататгаж байна.

Судалгаанд хамрагдсан гарааны компаниудын татсан санхүүжилтийн мөнгөн дүнгээс харахад Angel болон Pre-seed шатанд харьцангуй бага хэмжээний хөрөнгө оруулалтууд хийгдэж байна. Харин Seed болон Series шатанд авсан мөнгөн дүнгийн мэдээлэл нь бодит байдалтай нийцэхгүй байх магадлалтай гэж судалгааны баг үзсэн ба хөрөнгө оруулалтын мэдээллийн ил тод байдал, үнэн зөв байдал, мөн гарааны компаниудын санхүүгийн боловсрол дутмаг байгааг илтгэж байна.

Зураг 15. Гарааны компаниудын үе шат болон татсан мөнгөн дүн (төгрөгөөр)



Хөгжсөн экосистемүүдэд Seed болон Series шатны хэлцлүүд нь ихэвчлэн хэдэн саяас хэдэн арван сая ам.долларын хэмжээтэй байдаг тул 50 сая төгрөг гэдэг нь тухайн үе шатны жишгээс хэт бага мөнгөн дүн юм.

Судалгаанд хамрагдсан гарааны компани, хөрөнгө оруулагчдын хооронд хөрөнгө оруулалтын хэлцэл хийх, шийдвэр гаргахад хамгийн их сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс нь бизнесийн үнэлгээ, хувь эзэмшил, бизнес дэх оролцоо болон шийдвэр гаргалт дээр тохирч чадахгүй байгаа байдал байна. Энэ нь Монголын экосистемд үнэлгээний стандарт тогтоогүй, эсхүл гарааны компаниуд өөрсдийн үнэлгээг хэт өндөр тавьдаг, хөрөнгө оруулагчид хувьцааны хяналтыг хэт их шаарддаг зэрэг асуудлууд байж болно.

Мөн бизнесийн оролцооны хувьд хөрөнгө оруулагчид зөвхөн санхүүжилт олгохоос гадна бизнесийн үйл ажиллагаанд оролцох, шийдвэр гаргалтад нөлөөлөх сонирхолтой байдаг нь анхлан бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулдаг байх талтай. Харин бизнесийн алсын хараа, зорилгын хувьд төдийлөн өндөр нөлөөлөл үзүүлдэггүй нь харьцангуй эерэг тал юм.

Судалгаанд хамрагдсан гарааны компаниудын хөрөнгө оруулалтын хэрэгцээг, үе шаттай харьцуулан хүснэгт 6-д харуулав.

Хүснэгт 12. Компаниудын хэрэгцээт санхүүжилт (үе шатаар)

Мөнгөн дүн (₮)	Angel	Pre-seed	Seed	Series
1-100 сая	23			
250 сая	5	2		
500 сая	2	6	7	
1 тэрбум	1	8	7	8
3 тэрбум		1	5	1
3 тэрбум дээш				4

Angel хөрөнгө оруулалт: 100 сая төгрөг хүртэлх хэрэгцээ хамгийн их байгаа нь эхний шатны гарааны компаниуд үндсэн бүтээгдэхүүнээ хөгжүүлэх, зах зээлд нэвтрэхэд шаардлагатай жижиг хэмжээний санхүүжилт хайж байгааг илтгэнэ.


Pre-seed, Seed үе: 500 саяас 1 тэрбум төгрөгийн хооронд хөрөнгө оруулалт татах хэрэгцээ мөн адил их байгаа ба бүтээгдэхүүнээ сайжруулж, хэрэглэгчийн баазаа өргөжүүлэх, багаа өргөтгөх зэрэгт илүү их хөрөнгө шаарддаг.

Series үе: 1 тэрбумаас дээш хөрөнгө оруулалт татах хэрэгцээтэй байгаа Series шатны буюу ихэвчлэн зах зээлд тогтвортой байр суурьтай, орлоготой, цаашид хурдацтай өсөх боломжтой компаниуд бөгөөд олон улсад гарах, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх зэрэг томоохон төслүүдэд зориулж санхүүжилт хайж байна.

Гарааны бизнесийн чиглэлээр 2024 онд нийт 234 арга хэмжээ зохион байгуулагдсан бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад мэдэгдэхүйц өссөн байна. Энэхүү өсөлт нь их, дээд сургууль, эрдэм шинжилгээний болон олон улсын байгууллагуудын энэ чиглэлд хийсэн сургалтын хөтөлбөрүүдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой. Мөн төрөөс инновацыг дэмжих бодлого идэвхжиж, тоон үзүүлэлтүүд сайжирсан нь үүнтэй бас холбоотой байж болно.

Тухайлбал, 2023 оныг 2024 онтой харьцуулахад гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэх сургалт, воркшоп 52-оор, гадаад арга хэмжээ 37-оор, хурдасгуур хөтөлбөрийн тоо 17, хакатон тэмцээн 13-аар, хөрөнгө оруулалттай холбоотой арга хэмжээ 15-аар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 16. Гарааны бизнесийн чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээ



Гарааны бизнесийн экосистемийн цаашдын хөгжилд 2025 онд зохион байгуулагдах дараах онцлох үйл ажиллагаанууд чухал нөлөөтэй байх болно. Эдгээр нь олон улсын

болон дотоодын арга хэмжээг хослуулсан бөгөөд санхүүжилт татах, мэдлэг солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой.

Хүснэгт 12. Гарааны бизнесийн чиглэлээр 2025 онд болох арга хэмжээ

Арга хэмжээний нэр	Сар											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Mongolian startup ecosystem map				x								
Spark										x		
ICT Expo										x		
Гарааны компани улсын уралдаан										x		
Startup World Cup Mongolia									x			
MonJA accelerator program									x			
Mon X										x		
She Loves Tech									x			
MICS 2025											x	
Эрдэм хакатон									x			
Switch											x	
Digital night												x

Эдгээр үйл ажиллагаа нь гарааны бизнесүүдэд шинэ мэдлэг, ур чадвар эзэмших, менторшип авах, хөрөнгө оруулагчидтай холбогдох, олон улсын зах зээлд гарах боломжийг олгох чухал платформууд юм.

БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

6.1 Дүгнэлт

Монгол Улсад гарааны бизнесийн экосистем хөгжлийн эхэн үеэ өнгөрч байгаа бөгөөд COVID-19 цар тахлын дараах үеэс эхлэн зах зээл дээрх хөөсрөлт багасаж, хөрөнгө оруулагчдын төлөв байдал хүлээлтийн шинжтэй болоод байна. Хэдийгээр эдийн засгийг сэргээх, идэвхжүүлэх засгийн газрын хөтөлбөр, олон улсын байгууллагуудын санхүүжилт байгаа ч, инновац, технологи, шинжлэх ухааны салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэхгүй байгаа нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах өрсөлдөхүйц шинэ санаа, инновацийн шийдэл бүхий гарааны компани компани гарч ирэхгүй байна.

Сүүлийн 2 жилд гарааны бизнес бойжуулдаг хамтын оффисууд хаагдаж, хурдасгуур хөтөлбөрүүдийн элсэлтийн тоо багассан нь үүний баталгаа юм. Томоохон компаниуд хөрөнгө оруулалтаа царцаах, гадаад улсаас хөрөнгө оруулалт хийх гарааны компани хайх, гадны гарааны компани бойжуулах хурдасгуур хөтөлбөр зарлаж байна. Гарааны бизнесийн тоо буурах, хөрөнгө оруулагчид сонирхохгүй байгаагийн гол шалтгаануудад манай улсад венчур сангийн тухай хууль эрх зүйн орчин байхгүй байгаагаас олон гарааны компани "үхлийн хөндий"-г давж чадалгүй дампуурах, хөрөнгө оруулалтын мэдээллээ хөгжингүй улс орнууд шиг нээлттэй зарладаггүй зэрэг асуудлууд нөлөөлж байна. Өнөөдрийг хүртэл экосистемийн тоглогчид хүртэл Монголын хамгийн өндөр үнэлгээтэй технологийн компани ямар компани байдгийг мэддэггүй бөгөөд нээлттэй мэдээллийн эх сурвалж байхгүй байна.

Цаашид энэ салбарт хөрөнгө оруулалт татахын тулд эхний ээлжинд салбарын дата мэдээллээ нэгтгэх, ил тод болгох, нэгдсэн мэдээллийн санд байршуулах ажлуудыг хийж, хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчинг сайжруулах хэрэгцээ шаардлага байна. Эдгээр алхмууд нь Монголын гарааны бизнесийн экосистемийг илүү таатай, урьдчилан таамаглахуйц, тогтвортой болгоход чухал үүрэг гүйцэтгэнэ. Мөн гарааны бизнес эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, үнэлгээ болон хувьцааны асуудлаар зөвлөгөө өгөх механизмыг бий болгох нь хөрөнгө оруулалтын хэлцлийн амжилтыг нэмэгдүүлэхэд тустай.

Монголын гарааны бизнесийн экосистем нь үлэмж их потенциалтай бөгөөд залуу, эрч хүчтэй баг, шинэлэг санаагаар дүүрэн. Экосистемийн оролцогч талууд хамтран

ажиллаж, дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр Монгол Улс нь бүс нутагтаа инновацын тэргүүлэгч төв болох боломжтой юм.

6.2 Зөвлөмж

Төрийн байгууллага инновацыг дамжуулах, кластераар хөгжих, бодлогын хувьд сайжруулах хэрэгтэй. Мөн түүнчлэн хөрөнгө оруулагчдын тоо цөөн байгаа нь гарааны бизнесийн хөгжилд тушаа болж байна. Гарааны бизнесийг хөгжүүлэхэд төрөөс тууштай дэмжих нь хамгийн чухал хүчин зүйл юм. Мөн төрийн оролцоо нь илүү таатай бодлогын орчныг бий болгож, сайн судалгааны үндсэн дээр хийгдэх ёстой гэж гарааны бизнес эрхлэгчид үзэж байна.

Түүнчлэн хөрөнгө оруулагчдын хомсдол нь гарааны бизнесийг хөгжүүлэхэд саад болж байна. Хандивлагчдын өнцгөөс харахад гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэх засгийн газрын амлалт нь гарааны бизнесийн өсөлтийг хурдасгах гол хүчин зүйл юм. Мөн нааштай, сайтар судлагдсан бодлого, зохицуулалтыг бий болгох замаар төрийн үүрэг оролцоо чухал байх ёстой гэж үзэж байна. Засгийн газар гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэхдээ хувийн хэвшлийн туршлагад тулгуурлан олон улсын хөрөнгө оруулагчдыг Монголд оруулж ирэхэд гол үүрэг гүйцэтгэх боломжтой юм.

Монголын гарааны бизнесийн экосистемийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах, тогтвортой хөгжлийг хангахын тулд дараах бодлого, стратегийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эдгээр зөвлөмжүүд нь судалгааны үр дүнд болон экосистемийн өнөөгийн нөхцөл байдалд тулгуурласан болно.

ОУ-ын хамтын ажиллагаа ба хөрөнгө оруулалт

- **Олон улсын хөтөлбөрүүдийг Монголд нэвтрүүлэх:** Дэлхийн тэргүүлэгч инкубатор, хурдасгуур хөтөлбөрүүдийг Монголд нэрэгдүүлэх, эсвэл дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.
- **Бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх:** Төв Ази, Зүүн Өмнөд Ази, Америк, Араб болон бусад өндөр хөгжилтэй орнууд дахь гарааны компаниудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэдлэг, туршлага солилцох платформуудыг бий болгох. Үүний тулд олон улсын хурал, үзэсгэлэн, бизнес аялалд оролцохыг дэмжих.

- **Гадаадын хөрөнгө оруулалтыг татах нөхцөлийг бүрдүүлэх:** Гадаадын венчур сан, хөрөнгө оруулагчдад зориулсан татварын хөнгөлөлт, хөрөнгө оруулалтын орчныг илүү таатай болгох хууль эрх зүйн шинэчлэл хийх. Мөн гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээллийн нэгдсэн сан, хөрөнгө оруулалтын гарын авлагыг боловсруулах.

Санхүүжилтийн олон талт эх үүсвэрийг бүрдүүлэх

- **Венчур сан болон хамтарсан хөрөнгө оруулалтын сан байгуулах:** Төрийн болон хувийн хэвшлийн хамтарсан венчур сангуудыг бий болгох, эсвэл олон улсын хөрөнгө оруулалтын сангуудтай хамтран Монголд венчур сангууд байгуулахыг дэмжих. Венчур сангийн тухай хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь нэн чухал.
- **Цахим краудфандинг платформыг ашиглах:** Fundea.mn зэрэг краудфандинг платформуудын үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн хөрөнгө оруулалт татах үйл явцыг илүү ил тод, итгэлцэлтэй болгох зохицуулалтыг бий болгох. Иргэд болон жижиг хөрөнгө оруулагчдыг гарааны бизнест хөрөнгө оруулахыг урамшуулах.
- **Хөрөнгө оруулалтын мэдээллийг ил тод болгох:** Хөрөнгө оруулагчид болон гарааны компаниуд хоорондоо хийсэн хэлцлийн мэдээллийг (мөнгөн дүн, үе шат, үнэлгээ) нээлттэй зарлах нэгдсэн тогтолцоог бий болгох. Энэ нь зах зээлийн бодит үнэлгээ, чиг хандлагыг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэнэ.

Экосистемийн хөгжил ба дэд бүтэц

- **Шинжлэх ухааны парк, технологи дамжуулах үндэсний стратеги төлөвлөгөө боловсруулах:** Засгийн газрын түвшинд Шинжлэх ухааны парк, технологи дамжуулах төвүүдийг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжих урт хугацааны стратегийг тодорхойлох.
- **Инновацын сан байгуулах:** Инновац, судалгаа хөгжүүлэлтийг дэмжих зорилгоор улсын болон хувийн хэвшлийн сангуудыг байгуулах.
- **Судалгаа хөгжлийг дэмжих, их сургууль болон бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах:** Их сургуулиудын эрдэм

шинжилгээний үр дүнг бизнест нэвтрүүлэх механизмыг сайжруулах, хамтарсан төсөл хөтөлбөрүүдийг урамшуулах.

- **Салбарын нэгдсэн дата мэдээллийг авах нэг дэд бүтэц, орц гарцтай болох:** Монголын гарааны бизнесийн экосистемийн бүх оролцогчдоос мэдээлэл цуглуулах, нэгтгэх, боловсруулах, ил тод байдлыг хангах нэгдсэн мэдээллийн сан эсвэл платформыг бий болгох. Энэ нь бодлого тодорхойлогчид, хөрөнгө оруулагчид болон гарааны компаниудад бодит мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах боломжийг олгоно.

Эрх зүй, бодлогын орчны сайжруулалт

- **Татварын болон татварын бус дэмжлэгийг нэмэгдүүлэх:** Гарааны бизнесүүд, ялангуяа технологийн гарааны компаниудад зориулсан татварын хөнгөлөлт, хөгжлийн зээл, баталгаа зэрэг татварын бус дэмжлэгийг нэмэгдүүлэх.
- **Гарааны бизнесийн санхүүжилтийн эрх зүйн орчныг сайжруулах:** Венчур сан, хөрөнгө оруулалтын гэрээ, хувьцааны үнэлгээ зэрэгт холбогдох хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох. Ингэснээр хөрөнгө оруулагчид болон гарааны компаниудын хоорондын харилцааг илүү тодорхой, итгэлцэлтэй болгоно.
- **Мэдээллийн технологи, дэвшилтэт технологийн үйлдвэрлэлийг дэмжих төрийн бодлого хэрэгжүүлэх:** МТ болон инновацын салбарыг дэмжих бодлогын уялдаа холбоог сайжруулах, холбогдох зөвлөлүүдийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Нэг. Монгол Улсын хууль

1. Инновацийн тухай хууль
2. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль
3. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль
4. Хөрөнгө оруулалтын тухай хууль
5. Оюуны өмчийн тухай хууль

Хоёр. Бодлогын баримт бичиг

6. “Алсын хараа – 2050” урт хугацааны хөгжлийн бодлого

Гурав. Судалгаа, статистик

7. Дэлхийн инновацын индексийн тайлан, 2024, ДООБ
8. Дэлхийн гарааны бизнесийн экосистемийн индексийн тайлан, 2025, СтартапБлинк
9. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийн тандан судалгааны тайлан, 2024, ЦХХХЯ
10. Монголын гарааны бизнесийн зураглал, 2022, 2023, ЖАЙКА, Старт ХХК
11. Startup ecosystem maps 2025
12. Монгол Улс дахь МХХТ, цахим үйлдвэрлэл ба гарааны бизнесийг хөгжүүлэх нөхцөл байдлын судалгаа, 2025, ЖАЙКА
13. Гарааны бизнесийн санхүүжилтийн хүртээмж, З.Алтанчимэг, Ж.Сарантуяа, Ц.Болортуяа
14. Жижиг, дунд үйлдвэрийн газрын албан ёсны цахим хуудас

ХАВСРАЛТ

ГАРААНЫ КОМПАНИ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СУДАЛГААНЫ АСУУМЖ

1. Таны бизнесийн нэр: _____
2. Танай бизнес аль шатандаа явж байна вэ?
 - ☐ Angel
 - ☐ Pre-seed
 - ☐ Seed
 - ☐ Series A буюу түүнээс дээш
3. 2024 онд танай бизнес ямар хэлбэрийн санхүүжилт авсан бэ? (Олон хариулт сонгож болно)
 - ☐ Хөрөнгө оруулалт
 - ☐ Зээл
 - ☐ Буцалтгүй тусламж, грант
 - ☐ Хамтын санхүүжилт
 - ☐ Санхүүжилт аваагүй
4. Санхүүжилт авсан бол нийт хэдэн төгрөгний санхүүжилт авсан бэ?
 - ☐ Санхүүжилт аваагүй
 - ☐ 1.5 саяаас доош
 - ☐ 1.5-50 сая
 - ☐ 50-200 сая
 - ☐ 200-1 тэрбум
 - ☐ 1 тэрбумаас дээш
5. Таны бизнесийн хувьд дараах санхүүжилтийн хэлбэрүүдийн хүртээмж хэр байна вэ?

Санхүүжилтийн хэлбэр	Маш хүртээмжтэй	Хүртээмжтэй	Дундаж	Хүртээмжгүй	Огт хүртээмжгүй
Хөрөнгө оруулалт	☐	☐	☐	☐	☐

Санхүүжилтийн хэлбэр	Маш хүртээмжтэй	Хүртээмжтэй	Дундаж	Хүртээмжгүй	Ог хүртээмжгүй
Буцалтгүй тусламж, грант	☐	☐	☐	☐	☐
Хамтын санхүүжилт (Fundeа.mn гэх мэт)	☐	☐	☐	☐	☐

6. Хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийхэд тулгарч буй гол хүндрэл юу вэ? (3 хариулт сонгоно уу)

- ☐ Бизнесийн үнэлгээ дээр тохирохгүй
- ☐ Хувь эзэмшил дээр тохиролцоогүй
- ☐ Хөрөнгө оруулагчийн оролцоо хэт их
- ☐ Хууль эрхзүйн ойлгомжгүй орчин
- ☐ Санхүүгийн тайлагналын бэлэн бус байдал
- ☐ Бусад: _____

7. Таны бизнест одоо ямар хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байна вэ?

- ☐ 1-100 сая
- ☐ 250 сая
- ☐ 500 сая
- ☐ 1 тэрбум
- ☐ 3 тэрбум
- ☐ 3 тэрбум ба түүнээс дээш

ГАРААНЫ БИЗНЕСИЙН ЭКОСИСТЕМИЙН ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН СУДАЛГААНЫ АСУУМЖ

1. Байгууллагын нэр: _____

2. Байгууллагын төрөл:

- ☐ Төрийн байгууллага
- ☐ Олон улсын байгууллага
- ☐ Төрийн бус байгууллага
- ☐ Их сургууль / Шинжлэх ухааны байгууллага
- ☐ Бизнесийн байгууллага
- ☐ Хурдасгуур / Инкубатор

3. 2024 онд хэдэн гарааны компанит бизнест санхүүжилт олгосон бэ?

4. Санхүүжилтийн нийт дүн: _____

5. Санхүүжилтийн төрөл (олон хариулт сонгох боломжтой):

- ☐ Хөрөнгө оруулалт
- ☐ Зээл
- ☐ Буцалтгүй тусламж, грант, шагнал
- ☐ Хамтын санхүүжилт (fundera.mn)

6. Санхүүжилтийн хэлбэрүүд (олон хариулт сонгох боломжтой):

- ☐ Ажил үйлчилгээ
- ☐ Бэлэн мөнгө
- ☐ Хосолсон (бэлэн мөнгө+ажил үйлчилгээ)

7. Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд:

Санхүүжилтийн эх үүсвэр	Ашигласан эсэх	Хамгийн их дүн	Хамгийн бага дүн
Спонсор	☐ Тийм ☐ Үгүй	_____	_____
Хөрөнгө оруулалтын компани	☐ Тийм ☐ Үгүй	_____	_____
Хамтын санхүүжилт	☐ Тийм ☐ Үгүй	_____	_____

8. Санхүүжилт олгоход компаниудад тавьдаг хамгийн чухал шалгуур үзүүлэлт юу вэ? (3 хүртэл сонгоно уу)

- ☐ Бизнесийн боломж/зах зээл
- ☐ Багийн чадавх
- ☐ Санхүүгийн тайлангийн бэлэн байдал
- ☐ Инновацын шинэлэг байдал
- ☐ Нийгмийн нөлөө
- ☐ Бусад: _____

9. Танай байгууллага 2025 онд гарааны бизнесүүдийг дэмжих ямар нэгэн хөтөлбөр, эвент зохион байгуулахаар төлөвлөж байна уу?

- ☐ Тийм _____
- ☐ Үгүй